МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН СЭТГҮҮЛ

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

2014 ОНЫ 11 САР. №19 (077)

ҮНЭТ ЦААС
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨРСӨНД УРГАХ ҮР

БИЧИЛ САНХҮҮ
ИРГЭДИЙН ЗЭЭЛИЙН “ХЭТЭВЧ”

ҮЗЭЛ БОДОЛ
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

WWW.MONGOLIANECONOMY.MN

САНХҮҮГИЙН МЕНЕЖЕР

ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЦОГЦЛООН БҮТЭЭСЭН ОН ЖИЛҮҮД



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ | МОНГОЛЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО | МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО | МБББСБ-УУДЫН ХОЛБОО | ХЗХ-ДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО | АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО | МОНГОЛЫН ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧДЫН ХОЛБОО | ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧДИЙН ХОЛБОО |

МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН БИРЖ

ЗАСГИЙН ГАЗРЫН ЖИЖИГЛЭНГИЙН ҮНЭТ ЦААС МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР АРИЛЖИГДАЖ БАЙНА

www.mse.mn



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ӨРГӨН БОЛОМЖ БАЙНА

Монголын хөрөнгийн биржийн зүгээс хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлэх, шинэ бүтээгдэхүүнийг гаргаж зах зээлд нэвтрүүлэх, шаардлагатай дэд бүтцийг бий болгох, компанийн засаглалыг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчинд нийцүүлэн дүрэм журмуудыг боловсруулан гаргах, жижиг дунд бизнес эрхлэгчдэд хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох боломжийг нээж өгөх, хөрөнгө оруулагчдын боловсролыг дээшлүүлэхэд бодлогын төвшинд анхаарал хандуулан, ажлуудыг хийж эхлүүлээд байна. Үүнд:

Зөвхөн хувьцаа арилждаг байсан бол Засгийн газрын үнэт цаас дахин Монголын хөрөнгийн биржээр арилжигдахаар боллоо

Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаас /ЗГЖҮЦ/ буюу Хувь хүн аж ахуй нэгжид зориулсан нэгж бүр нь 100,000 /Нэг зуун мянга/ төгрөгийн төгрөгийн нэрлэсэн үнэтэй, тогтсон хугацаанд хүү төлдөг /тогтмол хугацаанд эсхүл үнэт цаасны хугацааны эцэст/ үнэт цаасыг зах зээлд нэвтрүүлэн, арилжиж эхлээд байна.

Засгийн газрын аливаа өрийн бичиг, үнэт цаас нь хамгийн эрсдэлгүй хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тооцогддог бөгөөд тус үнэт цаасны хүүгийн орлого нь албан татвараас бүрэн чөлөөлөгддөг.

ЗГЖҮЦ нь хөрвөх чадвартай байдаг бөгөөд үнэт цаасыг хугацаа нь дуусахаас өмнө бусад этгээдэд худалдах, бэлэглэх, барьцаалах бүрэн боломжтой юм.

2014 оны 11 сарын 04-ний өдрийн анхдагч зах зээлийн арилжаагаар 12 долоо хоногийн хугацаатай, жилийн 15.795 хувийн өгөөжтэй, 4.5 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнийн дүнтэй нийт 45,020 ширхэг ЗГҮЦ худалдан авах захиалга ирснийг Сангийн яамны зүгээс 100% нийлүүлэлтийг баталгаажуулсан. Тус үнэт цаасны анхны арилжаагаар дээрх үнийн дүнтэй захиалга ирсэн нь зах зээл дээр эрэлт их байгааг харуулж байна.

ЗГЖҮЦ-ны арилжаанд оролцохын тулд Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв /www.schcd.mn/-д

үнэт цаасны данс нээлгүүлэх шаардлагатай ба үүнийг брокер, дилерийн компаниар дамжуулан гүйцэтгэнэ. Үнэт цаасны данстай тохиолдолд харилцагч брокер, дилерийн компанидаа захиалгаа өгч, төлбөр гүйцэтгэснээр захиалга баталгаажих болно.

ЗГЖҮЦ-ны арилжааны саналыг хуанлийн зургаан хоногийн турш авах бөгөөд зургаа дахь хоногт арилжааг хаах буюу Долоо хоног бүрийн мягмар гариг байна.

Мөн үүсмэл санхүүгийн хэрэгслийн нэг төрөл болох “Валютын фьючерсийн гэрээ” шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх чиглэлээр судалгааг хийж байгаа бөгөөд ирэх онд тус үнэт цаасны туршилтын арилжааг хийх бөгөөд хэрэв тус туршилтын арилжаа нь амжилттай болсон тохиолдолд зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Мэдээллийн шуурхай байдлыг хангах зорилгоор Мобайл апплекейшнийг зах зээлд нэвтрүүллээ

Монголын хөрөнгийн бирж нь өдөр тутмын арилжааны болон ханшийн мэдээллийг гар утас болон хөдөлгөөнт төхөөрөмжид зориулагдсан мобайл апплекейшны тусламжтайгаар олон нийтэд хүргэх боломжтой боллоо. Тус программыг ашиглахын тулд App Store-д “MN Stocks” гэсэн апплекейшныг татан суулгах хэрэгтэй. Уг программыг ашигласнаар хөрөнгө оруулагч нь ханшийн мэдээллийг тавин минутын хоцрогдолтойгоор хүлээн авахаас гадна өөрийн сонирхсон үнэт цааснуудаар багц үүсгэх боломжтой болж байна.

Ухаалаг гар утсанд зориулан гаргасан апплекейшн нь 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдөр “Apple Store”-д тавигдсанаас хойш 11 дүгээр сарын 1-ний байдлаар 300 гаруй хэрэглэгч тус апплекейшныг татаж аваад байна.

Үнэт цаас гаргах, хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох процесс хялбарчлагдлаа

Зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, үнэт цаас гаргах процессыг хялбарчлах, жижиг дунд бизнес эрхлэгчдэд хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох боломжийг нээж өгөх зорилгоор Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн журмыг шинэчлэн баталлаа.

Энэхүү журмын шинэчилсэн найруулгаар гадаадад бүртгэлтэй хуулийн этгээд Монголын хөрөнгийн биржид үнэт цаас гаргах, Монголд бүртгэлтэй компани гадаад улсад үнэт цаас гаргах буюу давхар бүртгэл хийлгэх, хувьцааны бүртгэлийн I, II, III гэсэн гурван ангилал, бүртгэлтэй компаниудын тогтмол биелүүлэх үүрэг буюу мэдээллийн ил тод байдлыг хангах, компанийн засаглалын зарчмыг дагаж мөрдөх талаар нэмэлт асуудлуудыг зохицуулж өгсөн бөгөөд бүртгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг олон улсын жишигт нийцүүлээд байна. Түүнчлэн МХБ-д үнэт цаас гаргагчид биржид төлөх төлбөр, хураамжийн хэмжээ буурахаас гадна шинээр III ангилал бий болгосноор жижиг, дунд бизнес эрхлэгчдэд компаниуд үнэт цаас гаргах боломж нээгдэж байна.

Нэгдүгээр самбар бол маш найдвартай ил тод хариуцлагатай компаниудын самбар юм. МХБ-ийн эл самбарт бүртгэгдэх компани бол Монголын корпорацийн засаглалын кодексийг тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байж бүртгэгдэнэ. Ингэснээр гадаад болон дотоодын хөрөнгө оруулагч нарт тодорхой хэмжээний итгэлцэл төрүүлнэ.

Хоёрдугаар самбарт бол Нэгдүгээр самбарынхаа шаардлагыг хараахан хангаж чадахгүй байгаа тэр компаниудыг оруулах юм.


Гуравдугаар самбар бол Монголд лиценз эзэмшиж байгаа уул уурхайн компаниудыг оруулах зорилготой ажиллаж байна.

Түүнчлэн “Үнэт цаасны арилжааны хяналтын журам”, “Гишүүнчлэлийн журам”-уудыг шинэчлэн боловсруулж баталлаа. Эдгээр журмаар гишүүн компаниудад тавих хяналт болон үнэт цаасны арилжааны хяналтын систем сайжрах, гишүүдийн чадавхийг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах зэрэг зохицуулалтууд хийгдсэн.

Хөрөнгө оруулагчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр:

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох” танхимын сургалтыг сар бүр зохион байгуулж, мөн байгууллага иргэдэд зориулж захиалгат сургалтыг явуулж байна. МХБ-ийн/www.mse.mn/ цахим хуудсаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хөрөнгийн зах зээлийн талаар болон бусад танин мэдэхүйн мэдээ мэдээллийн цаг алдалгүй хүргэж байна.




“БиДиСЕК” ҮЦХК
ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ САНХҮҮГИЙН
ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДЭМЖИНЭ
БРОКЕР
АНДЕРРАЙТЕР
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ
СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
“БиДиСЕК” ҮЦХК Төв оффис:
(976)-11-313108, (976)-11-321763
Брокер : 99042813 ; 99043165
www.bdsec.mn; info@bdsec.mn

LET FOREX

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА





ЗЭЭЛ

Бүх төрлийн зээлийг шуурхай олгоно

ИТГЭЛЦЭЛ

Мөнгө таны төлөө хөдөлмөрлөх ёстой

ВАЛЮТ АРИЛЖАА

Зах зээлийн ханшаар бэлэн болон бусаар

ФАКТОРИНГ

Авлага цуглуулах үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 9-р байр, 1 тоот

Утас/Факс: +(976)-11-323236
Гар утас: +(976)-99054028
Вэбсайт: www.letforex.mn
Цахим шуудан: contac@letforex.mn
/letforex

Нөгөөн хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Ийланд Роберт Мэн

ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

Б.Үүрийнтуяа

С.Батзаяа

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Барианжав / 9409-2904

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БЯМБАСАЙХАН
Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД
“Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажилллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

С.БЭХБАТ
ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН
МІН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮХ
СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА
“Пийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС
Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AB center. 504 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Хөрөнгийн зах зээл хөгжих хууль эрх зүйн үндэс Монголд байхгүй гэдэг үгийг 3-4 жилийн өмнө мэргэжлийн ч бай, мэргэжлийн бус ч бай амтай болгон нь хэлдэг байлаа. Тэгэхээс ч аргагүй үе байсан. Санхүүгийн зах зээлд банкны салбараас өөр бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжил сул, даатгал, хөрөнгө оруулалтын сан зэргийг хөгжүүлэх гэвч хууль эрх зүйн зохицуулалт, мэргэжилтэй боловсон хүчин дутмаг, за тэгээд олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг нэвтрүүлэх талаар бодож ярих ч сөхөөгүй тийм цаг үе байсан. Одоо ч манай хөрөнгийн зах зээлийн хөгжилд гялалзсан амжилт гараагүй ч санхүүгийн салбарт сүүлийн хэдхэн жилийн дотор алга эргүүлсэн мэт өөрчлөлтүүд гарч байгаа нь сайшаалтай. Учир юу гэвээс, санхүүгийн зах зээлд хууль эрх зүйн зохицуулалт хамгийн сайн хийгдсэн нь энэ сард тохиож буй Монголд санхүүгийн салбарт нэгдсэн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа явуулж эхэлсэн 20 жилийн ойн түүхийн хуудаснаас тодорхой харагдах ажээ.

Үүнийг гэрчлэх тоо баримт бидний Санхүүгийн зохицуулах хороотой хамтран бэлтгэн хүргэж буй үнэт цаасны зах зээлд зохицуулалт, хяналтын систем хэрхэн бий болж, сайжирч, ямар үр дүн гарч байгаа талаарх цогц мэдээлэл бүхий шинэхэн дугаарт маань цөөнгүй бий.

Тухайлбал, 1990-ээд оны эхээр хийгдсэн төрийн өмч хувьчлах бодлогын хүрээнд ямар ч шалгуургүйгээр 475 үйлдвэр, аж ахуйн нэгжийг бүртгэх замаар Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүссэн байдаг. Гэтэл энэ нь 20 жилийн дараа хөрөнгийн зах зээлд тодорхой цэвэрлэгээ, зохицуулалт, хариуцлага шаардах жишээтэй. Дурааpаа дургиж ирсэн хувьцаат компаниудыг хөрөнгийн захын тоглоомын дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулдаг болгох, цэгцлэх ажил руу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж хамтран 2011 оноос ханцуй шамлан орсон. Өдгөө Санхүүгийн зохицуулах хороонд үнэт цаас нь бүртгэлтэй 304 компани байгаагаас 200 нь хөрөнгийн биржийн арилжаанд оролцож байгаа аж. Хөрөнгийн биржийн лист цэвэрлэх ажиллагаа цаашид ч үргэлжлэх нь байна. Нэг үгээр шударга, хариуцлагатай, ил тод компани л Монголын хөрөнгийн биржид үйл ажиллагаа явуулах шинэ тогтолцоо бүрдэж эхэлсэн гэсэн үг.

Мөн “Эрдэнэс Тавантолгой” компанийн монгол хүн бүрт хуваарилсан 1072 ширхэг хувьцаатой холбоотой 2012-2013 онд борооны дараах мөөг шиг олшроод байсан брокер диллерийн компаниудын тоо ч огцом цөөрөөд байгаа гэнэ. Түүнчлэн 80 жилийн хөгжлийн түүхтэй Монголын даатгалын салбарт ч эрс өөрчлөлт гарч байгааг бид мэднэ. Үүнээс гадна 2000 оны дундуур олноороо дампуурч, олон хүнийг хохироогоод байсан Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаа ч тооноос чанарт шилжиж, хууль эрх зүйн зохицуулалт, хяналт нь сайн болсон байна. Одоо Монголд хадгаламж зээлийн хоршоо дампуурахгүй гэдэг баталгааг ч асуудал харицсан албаны хүмүүс амласан нь манай сэтгүүлийн хуудаснаа буулаа. Бичил санхүүд тооцогддог Банк бус санхүүгийн байгууллагууд ч үйл ажиллагаагаа хариуцлагатай тэлж, банкны зээлийн үйлчилгээний тодорхой хувийг нугалах болсон нь сайн хэрэг.

Хамгийн сүүлд нь тэмдэглэхэд, Үнэт цаасны зах зээлийн тухай болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай шинэ хуулиуд хэрэгжиж байгаа нь олон сайн өөрчлөлтийг авчрах нь дамжиггүй. Дээрх мэдээллүүдтэй холбоотой илүү дэлгэрэнгүйг манай сэтгүүлийн бусад материалаас авах болно.

Монголын эдийн засагт голлох үүрэгтэй оролцох учиртай санхүүгийн зах зээлийн ирээдүйн хөгжлийн зам тод томруун, гэрэл гэгээтэй харагдана. Гагцхүү энэ зах зээлийн хөгжил олон зүйлээс хамаардаг учраас өнөөдрийн бий болгосон сайн эрх зүйн зохицуулалт дээр иргэдийн санхүүгийн боловсрол ч чухал юм.

Орлогч эрхлэгч И.ОТГОНЖАРГАЛ

Монголын сэтгүүлдийн эвлэлийн "2013 оны Шилдэг сэтгүүл"



Борлуулах цэгүүд:

"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Фреско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр
"Max mall" дэх салбарууд


АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ

10 Мэндчилгээ
11 Хөрөнгийн зах зээлийн хөрсөнд ургах үр
14 Д.Баярсайхан: Олон улсад манай эрх зүйн орчныг хүлээн зөвшөөрсөн



17 Иргэдийн зээлийн "хэтэвч"
19 Тооноос чанарт шилжиж эхэлжээ
24 Санхүүгийн зохицуулах хороо ямар байгууллага вэ
25 Давхар даатгалын тогтолцооны эрэлд
28 Ө.Ганзориг: Хөрөнгийн зах хөгжихгүй байх нь эрсдэл



30 Хөрөнгийн зах зээлийн ирээдүйн чиг хандлага
32 Тоон мэдээ
34 Хороо ба холбоодын "нөхөрлөл"
35 Зохицуулах байгууллагын гадаад харилцаа
38 Насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролд
40 Он цагийн хэлхээс
42 Амьдралын их сургуульд ажилласнаа эргэн санахад сайхан байна
44 Санхүүгийн зах зээлд зохицуулагч зайлшгүй хэрэгтэй
46 Зураг түүх өгүүлнэ

МОНГОЛД

Хувьцаа



Монгол Улсын 780 орчим мянган иргэн өнөөдрийн байдлаар үнэт цаасны хадгаламжийн байгууллагад хувьцааны данстай байдгаас ердөө 10 мянга хүрэхгүй нь арилжаанд идэвхитэй оролцож хувьцааны үр ашиг, өгөөжийг хүртдэг аж. Харин үлдсэн хэсэг нь хувьцааны арилжаанд төдийлөн оролцдоггүй. Хөрөнгө оруулалтын эрхийн бичигээр хувьцаа авсан иргэдийн дийлэнх нь өөрсдийн хувьцаатай эсэхээ ч мэддэггүй, үнэт цаасны хадгаламжийн байгууллага дахь дансанд байгаа мөнгөө ч авдаггүй байна.

Иргэн та үнэт цаасны данстай эсэхээ шалгаж, дансгүй бол нээлгэж өөрийн хөрөнгө болох хувьцаагаа үнэт цаасны арилжаанд оруулж ханшийн зөрүүнээс ашиг олох, магадгүй олон жилийн хугацаанд хуримтлагдаад байгаа ногдол ашгийн мөнгөө авах боломжтой тул өөрсдийн хувьцааны дансаа шалгаснаар мэдэх боломжтой юм.

Үнэт цаас

Санхүүгийн зохицуулах хороонооос одоогийн байдлаар “Голомт банк”, “Худалдаа хөгжлийн банк” хоёрт үнэт цаасны зах зээлд кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгожээ.

ХААН банк уг үйлчилгээний зөвшөөрлийг авахаар хүсэлтээ иргүүлээд буй аж.

Банк үнэт цаасны зах зээлд кастодианы үйлчилгээг үзүүлснээр гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгжийн үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслийг найдвартай хадгалах, ногдол ашгийн мөнгөн төлбөр, тооцоог шуурхай гүйцэтгэх юм байна. Мөн хувьцаа эзэмшигчийн олгосон итгэмжлэлээр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагдах боломж бүрдэх аж.

Түүнчлэн гадаадын томоохон хөрөнгө оруулагчдыг манай орны үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг найдвартай хадгалан, сангийн хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулагдах явдлыг гаргуулахгүй байх давуу талтай.

Өнгөрсөн хугацаанд үнэт цаасны арилжааг нь зогсоосон 165 ХК-ийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Шүүхийн шийдвэрээр татан буугдаж, хуулийн этгээдийн эрх зүйн чадамжгүй болсон тул арилжааг нь зогсоогоод байсан “ЦАСТУ” ХК, “Чимбай” ХК, “Разноимпекс” ХК, “Туул баян” ХК, “Монел” ХК, “Модлог” ХК зэрэг компанийн үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хорооны энэ оны аравдугаар сарын 21-ний өдрийн 375 дугаар тогтоолоор үнэт цаасны бүртгэлээс хасчээ.

Даатгал

Санхүүгийн зохицуулах хороонооос даатгалын салбарын үзүүлэлтийг нэгтгэн гаргажээ. Энэ оны гуравдугаар улирлын байдлаар даатгалын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 135.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин нэмэгдсэн байна.

Харин даатгалын компаниудын өр, эзэмшигчийн өмчит нөөцийн сангийн эзлэх хувь хэмжээ 49 хувь болж өмнөх оны мөн үеэс гурван хувиар нэмэгдсэн нь даатгалын салбарын хяналт сайжирсантай холбоотой гэж мэргэжилтнүүд үзэж байна.

Түүнчлэн жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлого нийт даатгалын хураамжийн 18 хувийг эзэлж байгаа ч даатгалын нөхөн төлбөр нь нийт нөхөн төлбөрийн 34 хувийг эзэлж байгаа нь хохирол их байгааг харуулж буй аж. Даатгагчийн хохирлын харьцаа 42 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1.6 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм.

Оюутан



Санхүүгийн салбарын хяналт зохицуулалтын байгууллага үүсгэн байгууллагдсаны 20 жилийн ой энэ сард тохиож байна. Үүнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо хамтран Улаанбаатар хотын их, дээд сургуулиудын дунд оюутнуудын судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг үнэлэх, оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, онол практикийн мэдлэгийг нь гүнзгийрүүлэх зорилгоор “Оюуны эрэлд” эрдэм шинжилгээний хурлыг гурав дахь жилдээ зохион байгуулж буй аж.

Хуралд банк санхүү, бичил санхүүгийн зах зээлийн талаар сонирхон судалж, зах зээл дээр цаашид урт хугацаанд ажиллах сонирхолтой эдийн засаг, банк санхүү, маркетинг, менежментийн чиглэлээр суралцдаг оюутан залуучууд оролцох боломжтой юм байна.

Банк санхүү

Монголын банкуудын холбооны /МБХ/ Удирдах зөвлөлийн энэ оны аравдугаар сарын 23-ны өдрийн хурлаар МБХ-ны логоны шинэчилсэн загварыг баталжээ. Шинэ логоны санааг гаргахдаа нэгэн бүхэл, мөнхийн хувиршгүй, өөгүй цэвэр, бүрэн гүйцэд гэсэн утгыг илэрхийлдэг дугуй дүрснүүдийн нэгдэл дээр үндэслэн гаргасан аж. Түүнчлэн элдэв өнцөгүй, уян хэлбэртэй тул эв нэгдэл, зохицлыг илтгэнэ гэж үзсэн юм байна. МБХ нь банк болон санхүүгийн байгууллагуудыг нэгтгэсэн мэргэжлийн холбоо гэдгийг төлөөлүүлж зоосон дүрсийг нэмж оруулж өгчээ.


ДЭЛХИЙ ДАХИНД

Шанхай-Хонконгийн хөрөнгийн захын холбоос



Хонконг ба Шанхайн хөрөнгийн бирж энэ долоо хоногт харилцан солилцооны хамтын ажиллагааг албан ёсоор нээсэн нь Хятадын хувьд гадаадын хөрөнгийг татаж, дотоодын үнэт цаасуудыг олон улсын хөрөнгө оруулагчдад илүү дөхөм болгосон том алхам байлаа. Шинээр бий болгосон Шанхайн үнэт цаасны шууд арилжаа нь энэ сарын 17-ноос эхэлж байгаа бөгөөд өдрийн нийт арилжаа эхний ээлжинд 2.1 тэрбум ам.доллар байхаар тогтжээ. Шанхайд бүртгэлтэй, тодорхой хориг тогтоосон 500 үнэт цааст ийнхүү гаднын арилжаа хийхийг хүлээн зөвшөөрлөө. Үүний үр дүнд юанийн дэлхийн хэрэглээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ Шанхайн олон улсын санхүүгийн төв хэмээх байр суурийг илүү бататгах боломжтой юм.

Хөршүүд хийн тохиролцоог үзэглэлээ



Си Зинпинь болон В. Путин хоёр улсын хооронд хийх худалдааны өндөр ач холбогдолтой гэрээг үзэглэсэн бөгөөд энэ нь Хятадыг Оросын хийн хамгийн том хэрэглэгч болголоо. Энэхүү хийг Оросын баруун Алтайн шугамаар ханган нийлүүлэх бөгөөд өдөрт 30 тэрбум куб метрийг шахах аж. Зүүн Себирийн нутгаар тавихаар төлөвлөсөн хийн хоолойн ажил эхэлсэн бөгөөд Хятад руу гаргах хийн нийлүүлэлт нь Европ руу экспортолдгоос хэд дахин их байх аж. Үүнтэй холбоотой байгуулсан Ойлголцлын санамж бичиг нь тус хоёр улсын өмнө нь үзэглэсэн 17 гэрээний зөвхөн нэг нь билээ. Тэд Ази Номхон далайн Эдийн засгийн хамтын ажиллагааны дээд хэмжээний уулзалт Бээжинд болох үеэр ийнхүү тав дахь удаагаа уулзаж, хэлцлүүдийг баталгаажуулсан юм. Дээрх хийн хоолойнууд нь тойруу замаар тавигдаж байгаа бөгөөд Монголын баруун, зүүн хил орчмоор дайран өнгөрөх юм байна.

Туркойз Хилийн эргэн тойронд

Оюутолгойн компанийн үйл ажиллагааг хариуцагч “Туркойз Хил Ресурс” компанийн Ерөнхий захирал Кей Присетли ажлаа өглөө. Мөн Дэвид Клингнер албан тушаалаасаа бууж байгаа юм байна. Нийт 5.4 тэрбум ам.долларын санхүүжилт хэрэгтэй хэмээн тооцож буй Оюутолгойн хоёрдугаар шатны бүтээн байгуулалт жил гаруй хойшилж байгаагийн араас ийнхүү тус компанийн дотоод бүтцэд нэлээд өөрчлөлт орлоо. Монгол улсын Ерөнхий сайд Н. Алтанхуяг огцорч буй мэдээллээс үүдэн тус компанийн хувьцаа хоёр хувийн уналтыг үзүүлсэн ч Р.Амаржаргал гишүүнийг намаасаа сайдын суудалд нэр дэвшлээ гэх мэдээллийн мөрөөр хувьцаа дахиад өсч эерэг түвшинд очсон. Ч.Сайханбилэг дараагийн Ерөнхий сайдаар сонгогдох нь ил болоод буй энэ үед “Туркойз Хил Ресурс” -ийн хувьцааны ханш тогтвортой




байх бололтой.

Азийн үнэт цаасны ТОП тоглогч

Дэлхийн эдийн засаг хямралаас гарахаар салгалж байгаа энэ үед АНУ, Европ болон бусад хөгжиж буй бүсүүдийн хөрөнгийн захын 10 хувийн дундаж өсөлтийг давсан үзүүлэлтээр Азийн үнэт цаасны зах зээлүүд 2014 оны шилдэг тоглогчдоор шалгарч байна хэмээн “Уолл Стрийт Журнал” дүгнэлээ. Эдийн засгийн хүчтэй өсөлт, эерэг өөрчлөлтүүд нь Филлипин, Тайланд, Индонез болон Энэтхэгт тэнгэрт тулам өсөлт буюу 32 хувийн дунджыг авчирлаа. Үүнийг мөн шинээр сонгогдсон Энэтхэгийн Ерөнхий сайд Наренда Мондигийн дагуулж буй эерэг хүлээлттэй холбон тайлбарлаж байна.

“Apple” Оросын бүх хувьцааг авсан ч чадна.



“Apple” компанийн зах зээлийн үнэлгээ энэ долоо хоногт 652 тэрбум ам.долларт хүрсэн нь ОХУ-ын хөрөнгийн зах зээлийн үнэлгээнээс хэд дахин илүү байгаа бөгөөд тус улсын хөрөнгийн захад бүртгэлтэй хувьцаа бүрийг худалдаж авсан ч чадахаар байгааг “Блүүмберг”-ийн санхүүгийн шинжээчид хэлж байна. ОХУ-ын эдийн засаг Украйнтай үүсгэсэн асуудлаас үүдэн хүчтэй цохилтод ороод байгаа бөгөөд хөрөнгийн зах зээлийн хувьд энэ онд 30 хувийн уналт буюу 231 тэрбум ам.долларын алдагдалд ороод байгаа юм. “Apple” компанийн зах зээлийн үнэлгээ Орос төдийгүй Итали, Сингапур улсынхыг ч мөн даваад байгаа аж. ■

МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсад санхүүгийн салбарын хяналт, зохицуулалтын байгууллага байгуулагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан санхүүгийн салбарыг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмрээ оруулж хөдөлмөр зүтгэлээ зориулсан, бидэнтэй нэгэн зорилгын төлөө хамтран ажиллаж байгаа та бүхэндээ Санхүүгийн зохицуулах хорооны хамт олны өмнөөс болон хувийн зүгээс түүхт ойн мэндийг дэвшүүлье.

1994 онд Үнэт цаасны тухай анхны хууль батлагдсанаар Монгол Улсын Үнэт цаасны хороо байгуулагдаж хөрөнгийн зах зээл, түүнийг зохицуулж, хяналт тавих төрийн байгууллага болон түүнд оролцогч мэргэжлийн байгууллагуудын үндэс суурь тавигдаж, цаашдын хөгжлийн гарц нээгдсэн юм.

2005 оны арваннэгдүгээр сард Монгол Улсын Их Хурлаас Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг, 2006 оны 45 дугаар тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийг тус тус баталснаар Үнэт цаасны хорооны чиг үүргийг өргөтгөж, даатгал, бичил санхүүгийн салбарын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэхээр өөрчлөлт хийсэн юм.

Энэхүү өөрчлөлтийн хүрээнд Монголбанкны банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаанд хяналт тавих газар, Улсын Мэргэжлийн хяналтын газрын даатгалын салбарын үйл ажиллагаанд хяналт тавих газрыг тус тус Үнэт цаасны хороонд нэгтгэж Монгол Улсад банкнаас бусад санхүүгийн салбарын нэгдсэн хяналт, зохицуулалтын байгууллага бий болсон түүхтэй.

Үнэт цаасны хороо байгуулагдах үед 29 брокерийн пүүс 18 аймаг, гурван хотод үйл ажиллагаа явуулж байсан бол өнөөдөр Санхүүгийн зохицуулах хороо нь үнэт цаасны салбарт зохицуулалтай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд болон мэргэжилтэн 2540, даатгалын салбарт 17 даатгалын компани, 3552 даатгалын мэргэжлийн оролцогч, бичил санхүүгийн салбарт 362 банк бус санхүүгийн байгууллага, 142 хадгаламж зээлийн хоршоодыг хамран зохицуулалт, хяналтын үйл ажиллагааг явуулж байна.

Бид энэ он жилүүдэд Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын гишүүн /IOSCO/ орон болж, мөн Олон улсын даатгалын хяналтын холбооны гишүүн /IAIS/ орон болсноор дэлхийн түвшинд Монгол улсын санхүүгийн салбарын хөгжлийг таниулж, цаашдын харилцаагаа улам өргөжүүлж байгааг тэмдэглэхэд таатай байна.

Монгол Улсад Санхүүгийн салбарын хяналт зохицуулалтын байгууллага үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойн мэндийг өргөн дэвшүүлж эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН

ҮНЭТ ЦААС

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨРСӨНД УРГАХ ҮР



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

Орчин цагийн супермаркетийг бий болгожээ. Харин одоо дэлгүүрт зарах бүтээгдэхүүн хэрэгтэй байна.

Б.ЭНХЦЭЦЭГ

Жилийн дөрвөн улиралд, цаг агаарын хүнд ширүүнийг үл хайхран хар захын задгай талбайд өөрийн урласан модон сийлбэр эдлэлүүд, төрөл бүрийн тавилга, монгол гэрээ чанга дуугаар хашгиран сурталчилж, хэрэглэгчдэд хүргэдэг залуу н.Болд хэдэн жилийн дараа жижиг хэмжээний үйлдвэртэй болохыг мөрөөддөг. Тэрбээр магадгүй Монголыг дэлхийд таниулах брэндүүдийн нэгийг бий болгосон, олон нийтэд хувьцаагаа гаргаж үйлдвэрлэлээ тэлсэн жишиг компаниудын нэгийг ч байгуулж мэдэх. Өнөөдрийн “магадгүйд” маргаашийн бодит байдал нуугдаж л байдаг.

Манай улсын олон бизнес эрхлэгчид үйл явц нь арай хялбар гэдгээр нь банкнаас зээл авч, үйл ажиллагаагаа тэлэхийг илүүд үзнэ. Гэвч үүний нөгөө талд зээлийн хүүгийн эрсдэл, эргэн төлөлт, валютын ханшийн зөрүү гэх мэт эрсдэлүүд биднийг отож байдаг. Өнөөдөр монголчууд төдийлэн зүрхэлж ашигладаггүй хөрөнгө оруулалт татах бас нэг санхүүгийн арга хэрэгсэл бий. Энэ бол IPO буюу хөрөнгийн зах зээл дээр үнэт цаас гаргах. Тус санхүүжилтийн арга нь банкны зээлтэй зэрэгцэх үнэ цэнэтэй ба зарим талаар илүү ашигтай хувилбар. Энэ төрлийн хөрөнгө оруулалт нь урт хугацааны бөгөөд хүүгүй байдаг. Гэсэн ч цөөн захирлууд үүнийг сонгодог нь харамсалтай. Анхдагч зах зээл дээр үнэт цаас гаргах нь тэшүүрээр гулгахтай адил үйл явц гэж хэлж болох. Хэрвээ танд тодорхой хэмжээний ур чадвар, цаг хугацаа, бэлтгэл бас бага зэргийн аз байваас хөрөнгийн зах зээл дээр үнэт цаас гаргах нь хүлээж байснаас чинь ч илүү өндөрт хурдтай гаргах болно. Харин цагаа олоогүй, бэлтгэл тааруу яаран хөрөнгийн зах зээл дээр орж ирвээс, аз таниас харьж, шороотой холилдох эрсдэл өндөр.

Гаднын жишээг ярихаас илүү Монголын хөрөнгийн биржийн босгыг алхаж, үнэт цаасаар дамжуулан үйл ажиллагаагаа тэлж, зах зээлийн үнэлгээгээ нэмэгдүүлсэн цөөнгүй компани байдаг. Тухайлбал, “Би Ди Сек” компани нь анх 2006 онд Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээл дээр үнэт цаасаа гаргасан бөгөөд тухайн үед олон нийтээс татан төвлөрүүлсэн нийт хөрөнгө нь ердөө 750 сая гаруй төгрөг байсан аж. /Хүснэгт 1/ Тухайн үед зах зээлийн үнэлгээ нь нэг тэрбум төгрөг байсан бөгөөд түүнээс хойш хоёр удаа нэмэлт хувьцаа гаргасан

тус компанийн одоогийн үнэлгээ 27.4 тэрбум болтол өсөөд байгаа юм. “Би Ди Сек” компанийн дараа буюу 2008 онд хувьцаагаа гаргасан “Гермес центр” ХК тухайн үед 2.3 тэрбум төгрөгийн хөрөнгийг Монголын хөрөнгийн биржээс босгожээ. Тэр үед тус компанийн зах зээлийн үнэлгээ 7.8 тэрбум гаруй төгрөгөөр хэмжигдэж байсан бол өнөөдөр хоёр дахин өсөж 14 тэрбум гаруй болжээ. Дөрвөн жилийн өмнө тус компанийн хувьцааны ширхэгийн нэрлэсэн үнэ нь 100 төгрөг байсан бол одоо 180 төгрөг орчимд хэлбэлзэж байна. Гэхдээ өнөөдөр Монголын хөрөнгийн зах зээл дээр хувьцаа гаргасан нийт компаниуд бүгд амжилт дагуулсан гэвэл худлаа. Угаас дэлхийн түүхэнд ч хувьцаа гаргасан бүхэн хождог гэсэн жишиг байхгүй. Гэсэн хэдий ч Монголын хөрөнгийн биржийн арилжаа өдгөө ч олигтой сэргэсэн зүйл алга.

Монголын хөрөнгийн бирж дээр 2006 оноос хойш нийт 12 компани үнэт цаас гаргасан бөгөөд тэдний нийт зах зээлийн үнэлгээ 2008 онд 79 тэрбум байсан бол өдгөө дөрвөн жилийн дараах байдлаар 102 тэрбум болоод байгааг Монголын хөрөнгийн биржийн тайлан харуулж буй. Энэ нь хэдийгээр бусад орны хөрөнгийн зах зээлтэй харьцуулахад чамлахаар тоо ч уруудаж буй гэсэн үзүүлэлт бол биш. Харин өндийх боломж буйн дохио.

Энэ онд “БиДиСек” компани нэмэлт хувьцаа гаргасныг эс тооцвол сүүлийн хэдэн жил төдийлэн томоохон IPO хийгдээгүй. Монголын компаниудын хувьд ч эдийн засаг хүндэрсэн энэ үед энэ талаар бодох ч сөхөөгүй байгаа бололтой. Гэвч нэг талаар үнэт цаас гаргаж, олон нийтэд хүртээмжтэй компани болох бэлтгэлийг ийм л цаг үед хийдэг ба цаг үеийн тохироо бүрдэнгүүт ажил хэрэг болгох нь зүйтэйг мэргэжилтнүүд хэлдэг.

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Т.Жамбаажамц “Олон нийтэд хувьцаа болон бусад төрлийн үнэт цаас гаргахад хууль тогтоомж, зохицуулалтын хувьд одоо үнэт цаасны зах зээлд саад гэхээр зүйл байхгүй” гэв.

Хөрөнгийн зах зээлийн хөрс болох Үнэт цаасны тухай хуулийг өнгөрсөн онд шинэчлэн баталж, энэ оны эхнээс хэрэгжүүлж эхэлсэн. Тус хууль нь Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд олон гарцыг нээж өгч, зах зээлийн шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүн тухайлбал, кастадион үйлчилгээ, давхар бүртгэл, хадгаламжийн бичиг /DR/ зэргийг нэвтрүүлэх боломжийг олгосон. Үүнтэй холбогдуулан үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээ буюу кастадион үйлчилгээг тусдаа байгууллага байгуулахын оронд тодорхой банкинд хариуцуулахаар болсон билээ. Одоогоор тус үйлчилгээг үзүүлэх эрхийг “Голомт” болон “Худалдаа Хөгжлийн” банк авсан бөгөөд техникийн бэлтгэл ажлыг хангаад явж байгааг Санхүүгийн зохицуулах хорооноос мэдээллээ. Харин дотоодын болон гаднын биржид давхар бүртгүүлэх боломжийн хувьд том нөөц боломж байгаа ч одоохондоо хараахан ашиглаж эхлээгүй байна.

Үнэт цаас гаргах сонирхолтой компаниудын хувьд нэг талаас хувьцааг нь худалдаж авах хөрөнгө оруулагчид байгаа болов уу гэх айдас байдаг. Харин тус зах зээлд гэгээ татуулж мэдэх хуулийг өнгөрсөн жил УИХ баталсан. Хөрөнгийн зах зээлийн томоохон тоглогчдын нэгт тооцогддог хөрөнгө оруулалтын сангууд нь мэргэжлийн хүмүүсээр удирдуулсан байдаг учир алдаа гаргах нь ч ховор. Тиймээс хөрөнгийн зах зээл дээр бие даан тоглох боломж дутмаг хүмүүсийн хувьд тус төрлийн сангууд нь сонгодог хувилбар болдог онцлогтой. Мөн гаднын орнуудад тэтгэврийн хувийн сангууд нэлээд түгээмэл бөгөөд хүмүүс ашиглагдахгүй сул хэвтэж байдаг уг мөнгөө эргүүлдэж, насны эцэс дэх амьдралаа баталгаажуулах нь элбэг. Бидэнд ч энэ боломж бүрэн бий. Хууль батлагдснаас хойш төдийлэн хөрөнгө оруулалтын сан гэвэл тоймтой байгууллага бүрэлдчихээгүй байгаа ч тус бизнесийг сонирхох хүн цөөнгүй байгаагийн зэрэгцээ хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах эрхтэй хөрөнгө оруулалтын менежментийн хоёр компани байгуулагдаад байгаа юм байна. Аливаа шинэ бүхэнд хугацаа бас бэлтгэл хэрэгтэй. Ямартай ч бид хөрөнгийн зах зээлийнхээ тоглогчдынхоо хүрээг тэлж чадсан.

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Т.Жамбаажамц “Эхний ээлжинд гаднынхан түлхүү хөрөнгө оруулалтын санг сонирхох нь дамжиггүй. Тухайлбал, алт, үл хөдлөх, хувьцаа, Засгийн газрын бондод хөрөнгө оруулах хувийн хөрөнгө оруулалтын сангууд байгуулах талаас тэд сонирхож байна. Гэвч манай улсын хөрөнгө оруулалтын орчин тогтворгүй, макро эдийн засгийн үзүүлэлтүүд тааруу байгаагаас тэд эмээгээд байгаа нь харагдаж байна” хэмээлээ.

“Эхний ээлжинд гаднынхан түлхүү хөрөнгө оруулалтын санг сонирхох нь дамжиггүй. Тухайлбал, алт, үл хөдлөх, хувьцаа, Засгийн газрын бондод хөрөнгө оруулах хувийн хөрөнгө оруулалтын сангууд байгуулах талаас тэд сонирхож байна. Гэвч манай улсын хөрөнгө оруулалтын орчин тогтворгүй, макро эдийн засгийн үзүүлэлтүүд тааруу байгаагаас тэд эмээгээд байгаа нь харагдаж байна”

Харин одоо юу хэрэгтэй байна вэ гэвэл хөрөнгийн зах зээл дээр зарагдах бүтээгдэхүүн хэрэгтэй. Хувийн хэвшлийнхэн төдийлэн зүрхэлж орж ирэхгүй байгаа энэ үед Төрийн өмчит компаниудыг хөрөнгийн биржээр хувьчлах нь одоогийн нөхцөлд нэг талаас хөрөнгийн зах зээлийг дэмжиж, хөрөнгө оруулагчдыг татах, нөгөө талаас төрийн өмчийн эзэмшлийн хувь хэмжээг багасгах, түүнийг үнэ хүргэж зарах гэсэн зорилтод нийцэж буй сайн хувилбар гэж үзэх хүн олон. Харин 2014-2016 онд хувьчлах төрийн өмчит 22 компаниас ердөө дөрөвхөнийг нь л хөрөнгийн биржийн анхдагч зах зээлээр олонд нээлттэй арилжаална гэж заасан байгаа. Энэ нь нэг талаас горьдлого тээн харуулдсан хөрөнгийн

Олон нийтээс татсан хөрөнгө

№	Симбол	Хувьцаат компанийн нэр	IPO хийхэд бүртгэгдсэн хувьцааны тоо	Бүртгэгдсэн огноо	Анх олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгө			IPO хисэн өдрөөр зах зээлийн үнэлгээ	2014/11/06 хаалтын ханш	2014/11/06 өдрөөр зах зээлийн үнэлгээ
					Хувьцааны тоо ширхэг	Зах зээлд анх санал болгосон /төг/	Нийт үнийн дүн /төг/			
1	MRX	“Мерекс” ХК	65 005 000,00	2014-01-14	26 000 000,00	100,00	2 600 000 000,00	6 500 500 000,00	100	6 500 500 000,00
2	ETR	“Э-Транс ложистикс” ХК	46 200 000,00	2012-04-09	7 700 000,00	120,00	924 000 000,00	5 544 000 000,00	90,9	4 199 580 000,00
3	MDR	“Монголиан девелопмент ресорсес” ХК	13 750 000,00	2010-06-30	13 750 000,00	1 000,00	13 750 000 000,00	13 750 000 000,00	520	7 150 000 000,00
4	HGN	“Хөх ган” ХК	101 317 557,00	2008-07-30	30 395 272,00	105,13	3 195 456 280,00	10 651 519 216,21	117	11 854 154 169,00
5	NKT	“Нако түлш” ХК	11 000 000,00	2007-11-29	9 000 000,00	100,00	900 000 000,00	1 100 000 000,00	285	3 595 480 485,00
6	RMC	“Ремикон” ХК	127 642 623,00	2008-05-19	50 480 202,00	100,02	5 048 820 200,00	12 766 285 154,39	100,81	7 931 676 765,84
7	HRM	“Гермес центр” ХК	78 543 001,00	2008-05-16	23 562 900,00	100,00	2 356 290 000,00	7 854 300 100,00	179	14 059 197 179,00
8	OLL	“Оллоо” ХК	9 700 497,00	2007-09-12	5 820 299,00	100,00	582 029 900,00	970 049 700,00	111	1 076 755 167,00
9	HBO	“Хай би ойл” ХК	5 000 000,00	2007-05-02	4 000 000,00	100,00	400 000 000,00	500 000 000,00	391	3 610 598 788,00
10	BDS	“Би ди сек” ХК	10 000 000,00	2006-06-22	7 500 000,00	100,00	750 000 000,00	1 000 000 000,00	2499	27 489 000 000,00
11	JTB	“Женко тур бюро” ХК	100 000 000,00	2006-01-17	78 895 885,00	104,69	8 259 239 676,00	10 468 530 362,52	86,5	8 650 000 000,00
12	MSH	“Монгол шилтгээн” ХК	10 000 000,00	2005-05-25	1 000 000,00	800,00	800 000 000,00	8 000 000 000,00	649.96	6 499 600 000,00
		НИЙТ					39 565 836 056,00	79 105 184 533,12		102 616 542 553,84

зах зээлийнхний хувьд гонсойлт болж хувирсан. Харин энэ тал дээр Төрийн өмчийн хорооны Бүтцийн өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга Д.Болормаа “Бид зарим компанийг хамтарсан, хөрөнгө оруулалт татах хэлбэрээр төрийн эзэмшлийн хувь хэмжээг нь багасгах гэж байгаа. Компаниудын үнэ цэнийг өсгөж байж, цаашид хувьцаат компани болгох нь зүйтэй. Өнөөдөр дампуурлын ирмэгт тулчихсан, засаглал муутай, технологийн шинэчлэл хийх шаардлагатай компанийг шууд үнэт цаас болгоод гаргавал ямар ч үр дүнд хүрэхгүй. Өөрөөр хэлбэл, үнэт цаасыг нь авах хөрөнгө оруулагч олдохгүй” хэмээн тайлбарласан юм. Ирэх оноос хувьчилахаар төлөвлөж буй дөрвөн компанийн хувьд үнэт цаас болгон гаргахад шаардлага хангасан засаглал сайтай компаниуд гэж үзэж сонгосон гэдгийг тэрбээр мөн хэллээ. Эдгээр компанид “Авто импэкс”, “Хөтөлийн цемент шохойн үйлдвэр”, “Монгол шуудан”, “Багануур” ХК зэрэг багтаж байна.

Хөрөнгийн зах зээл зөвхөн төрийн компаниудыг хараад суухгүйгээр хувийн хэвшлийнхнийг татан оролцуулах тал дээр идэвхийлэх нь зүйтэй. Энэ бол гол тулгуур. Тиймээс үнэт цаас гаргахыг дэмжих үүднээс холбогдох мэргэжилтнүүдээс УИХ-д цаашид үнэт цаас гаргасан компанийг бодлогоор дэмжиж дунд хугацаанд шатлалтайгаар

Нэмж хувьцаа гаргасан компаниуд

№	Симбол	Хувьцаат компанийн нэр	Бүртгэгдсэн хувьцааны тоо	Бүртгэгдсэн огноо	Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгө		
					Тоо ширхэг	Санал болгосон үнэ	Нийт дүн
1	BDS	“БиДиСек” ХК	6 000 000,00	2014-01-15	6 000 000,00	1 931,00	11 586 000 000,00
2	SHG	“Шарын гол” ХК	1 707 404,00	2011-10-13	1 648 257,00	11 117,00	18 301 439 069,00
3	SIL	“Силикат” ХК	16 222 300,00	2011-05-06	16 222 300,00	225,00	3 650 017 500,00
4	SHG	“Шарын гол” ХК	1 292 596,00	2011-01-13	-		-
5	HBO	“Хай би ойл” ХК	2 234 268,00	2010-08-25	570 358,00	174,00	99 242 292,00
6	NKT	“Нако түлш” ХК	1 615 721,00	2010-08-25	1 180 195,00	229,00	270 264 655,00
7	BDS	“Би ди сек” ХК	1 000 000,00	2008-06-12	900 014,00	3 000,00	2 625 346 500,00
8	HBO	“Хай би ойл” ХК	2 000 000,00	2007-11-29	2 000 000,00	100,00	200 000 000,00
9	MIB	“Мониншбар” ХК	10 000 000,00	2007-01-16	10 000 000,00	100,00	1 000 000 000,00
		НИЙТ	37 732 310 016,00				

Эх сурвалж: СЗХ

татвараас чөлөөлөх хөтөлбөрийг өргөн барьчихаад байгаа юм байна. Үнэт цаас гаргасан компаниуд өнөөдөр ашгийн 10, 25 хувийн татвар төлдөг. Үнэт цаас гаргасан тохиолдолд үүнийг удаах гурван жилд 100 хувь, түүний дараагийн гурван жилд 50 хувь хөнгөлөх гэх мэт хөнгөлөлт эдлүүлэхээр зорьж байгаа аж.

Энэ тал дээр “БиДиСек” компанийн гүйцэтгэх захирал Д.Даянбилгүүн “25 хувийн татвар чангадаад байгаа юм биш. Хөрөнгийн зах зээл рүү компаниудыг татъя гэвэл урамшуулал хэрэгтэй. Яагаад энэ зах зээлд орж ирэх ёстой вэ гэдэг асуултад ийм давуу тал, боломж байна гээд тодорхой хариулт өгч, таатай орчинг санал болговол компаниуд үнэт цаасаа гаргана” гэж хэлж байна. Мөн тэрбээр тус зах зээлийн татварыг тэглээд хөрөнгийн зах зээл гаднын хөрөнгө оруулагчдад таатай орчин мөн цаашид тогтвортой байна гэдгийг зарлачихвал гаднын хөрөнгө оруулагчид Монголын компанийн хувьцааг гаднын аль нэг биржээс авах уу эсвэл Монголоос авах уу гэдэг шийдвэрийг жинлэж, манайх руу хандах боломж үүснэ гэсэн юм.

Олон компаниудын амжилтын үндсийг байгуулагчийнх нь авьяас, аз болон үзүүлж буй үйлчилгээ бүтээгдэхүүнийх нь оновчтой ба хүртээмжтэй байдал зэрэгтэй холбон тайлбарладаг. Гэвч хөрөнгө оруулалтын тохиромжгүй хувилбарыг сонгосноор компанийн ирээдүй бүдгэрч, өсөлт үлэмж хэмжээнд хазаарлагддагийг санхүүгийн мэргэжилтнүүд баталсан байдаг билээ.

Монголын үнэт цаасны зах зээлд хөгжил, хөшүүрэг бий болж байгаа ч улам бүр эрчимжүүлэх бодит хөрс хэрэгтэй байна. ■



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

ЗОЧИН

Д.БАЯРСАЙХАН: ОЛОН УЛСАД МАНАЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН

Б.БАЯРТОГТОХ

Монгол Улсад санхүүгийн зохицуулах байгууллага үүсч байгуулагдсаны 20 жилийн ой энэ онд тохиож байна. Үүнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхантай зохицуулах салбарын өнгөрсөн, одоо, ирээдүйн талаар ярилцлаа.

-Үнэт цаасны хороо байгуулагдсаны 20 жилийн ой тохиож байна. Тус хороо санхүүгийн зах зээлийн хөгжилд ямар түүхэн үүрэг гүйцэтгэсэн бэ?

-Санхүүгийн салбар дахь анхны зохицуулах байгууллага болох Үнэт цаасны хороо 1994 онд байгуулагдсан. Түүнээс хойш өдгөө 20 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд Монголын эдийн засагт маш том өөрчлөлт гарсан. Үүнийг дагаад санхүүгийн салбарт эргэлдэх мөнгөн хөрөнгийн хэмжээ өссөн. Улмаар зохицуулах байгууллагын үүрэг, хариуцлага ч нэмэгдсэн. Үнэт цаасны хорооны хувьд өөрийн үүргээ түүхэн хугацаанд амжилттай гүйцэтгэсэн. Үүний үр шимийг ч нийгэм тодорхой хэмжээнд хүртсэн. Хороо нь өмч хувьчлалын үед бий болсон бөгөөд анхны Үнэт цаасны тухай хуулийг баталж, холбогдох дүрэм журмыг нь боловсруулсан байдаг. Ингээд бидний хэлж заншсан их хувьчлал буюу ягаан, цэнхэр тасалбарын үед нийтдээ 475 хувьцаат компанийг байгуулсан байдаг. Эдгээр компанийг үүсгэн байгуулах ажлыг Үнэт цаасны хороо бүхэлд нь удирдсан. Энэ нь өнөөгийн хөрөнгийн захын хөгжих суурь болсон. Тухайн үед Үнэт цаасны хорооны мэдэлд Монголбанкнаас бичил санхүүгийн хэлтэс, Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Даатгалын газар ирж одоогийн Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсан. Хорооны чиг үүрэг хуулиараа их өргөн. Зохицуулах байгууллагын хүрээнд арилжааны банкуудаас бусад санхүүгийн үйлчилгээг үзүүлэх газрууд хамаардаг.

-Нийгэм, эдийн засгийн амьдралд ч багагүй өөрчлөлт гарсан. Тухайлбал, өнгөрсөн хугацаанд танай аль нэг салбарт гарсан бодит өөрчлөлтийг онцлохгүй юү?

-Нэг бодит жишээ нь даатгалын салбар байна. Дөнгөж хороо байгуулагдах үед 21 даатгалын компани үйл ажиллагаа явуулж байсан. Тэдний санхүүгийн чадвар сул, зах зээл нь зогсонги, эрсдэлд өртөмтгий, эмзэг байсан. Тэгвэл өнөөдөр эрсдэлээ даах чадвартай 17 компани өрсөлдөөнт зах зээлд ажиллаж байна. Энэ бол 20 жилийн хугацаанд бий болсон томоохон өөрчлөлтийн зөвхөн нэг нь. Мэдээж даатгалын салбар төдийгүй санхүүгийн зах зээл хөгжих, илүү сайжрах шаардлага бий. Гэхдээ ард үлдсэн цаг хугацааны ололтыг үнэлж, түүнээс суралцах ёстой. Хорооны хувьд арилжааны банкны үйл ажиллагаанд зохицуулалт хийх эрхгүй. Тэгвэл сүүлийн үед банкуудад хороо өөрийн зөвшөөрөл олгож эхэлсэн. Энэ нь хөгжлийн бас нэг үзүүлэлт байх гэж бодож байна. Банкууд даатгалын зуучлалын үйл ажиллагаа болон кастодианы үйлчилгээний эрх авахаар хандах болсон. Өөрөөр хэлбэл, хорооны зохицуулалтад банкны салбар орж ирж байна. Өнгөрсөн хугацаанд санхүүгийн салбарт хадгаламж зээлийн хоршоог дагасан хямрал гарч байсан. Үүнийг тодорхой ажлын хүрээнд цэгцэлсэн. Төрөөс хохирлыг нь барагдуулсан. Одоо хадгаламж зээлийн хоршоо бие даасан хуультай, зохицуулалттай боллоо.

-Компанийн засаглалыг сайжруулах хүрээнд танайх ямар ажил хийсэн бэ?

-Компанийн засаглал ч манайд хамаарч байгаа. Энэ чиглэлд хэд хэдэн томоохон ажил хийгдээд явж байна. Хорооны зүгээс засаглалын үндэсний кодексыг баталж гаргасан. Мөн Компанийн тухай хуульд засаглалтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийг оруулаа. Монгол Улс албан журмын даатгалын тогтолцоогүй

орны нэг байсан. Тэгвэл өнгөрсөн гурав хүрэхгүй жилийн хугацаанд Жолоочийн хариуцлагын даатгалыг хуульчлан батлууллаа. Үндсэндээ албан журмын даатгалын тогтолцоог бүрдүүлсэн гэж хэлж болно. Өнгөрсөн зургаан жилийн хугацаанд бүх салбарын хуулиудаа шинэчилсэн. Хамгийн сүүлд Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж холбогдох байгууллагад нь өргөн барьсан. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль хэрэгжиж байна. Товчхондоо, эрхзүйн зохицуулалт, хяналтын түвшинд нэлээд амжилт гаргасан он жилүүд байлаа.

-Манай үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчин дэлхийн түвшинд ойртсон гэж үзэж болох уу?

-Үнэт цаас болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль энэ оны нэгдүгээр сараас хэрэгжиж эхэлсэн. Энэ хугацаанд тухайн хуулийг дагасан холбогдох дүрэм, журмыг боловсруулж эцэслэн баталж гаргалаа. Дээрх хуулиуд гарснаар олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх, эрх зүйн таатай орчин бүрдэх чухал алхам болсон. Эдгээр өөрчлөлтийн үр дүнд манайх Олон улсын үнэт цаасны байгууллагуудын холбооны бүрэн эрхт гишүүн орны нэг боллоо. Ингэснээр үнэт цаасны холбоодын гишүүн улсуудтай ижил тэгш хэмжээнд харилцах, хамтран ажиллах, мэдээлэл солилцоход нээлттэй болсон. Өөрөөр хэлбэл, Олон улсад манай эрх зүйн орчныг хүлээн зөвшөөрсөн.

Дэлгүүрээр зүйрлэвэл бид “супермаркет”-тай болчихлоо

-Монголын хөрөнгийн биржийн шинэчлэлд тулгамдаж буй ямар асуудал байна вэ?

-Лондоны хөрөнгийн бирж, Монголын хөрөнгийн биржийн хооронд байгуулсан гэрээг сунгаад явж байгаа. Гэрээний хүрээнд өндөр хөгжсөн зах зээлийн технологи, мэдээллийн сан, программ хангамжийг өөрийн орны зах зээлд нутагшуулах ажил сүүлийн гурван жилд хийгдсэн. Одоо зах зээлийг хөгжүүлэхэд бүтээгдэхүүн нийлүүлэх нь чухал болоод байна. Дэлгүүрээр зүйрлэвэл бид орчин цагийн шаардлага хангахуйц “супермаркет”-тай болчихлоо. Одоо түүнд арилжаалах бараа бүтээгдэхүүн хэрэгтэй. Харамсалтай нь өнөөдрийн байдлаар нийт бүртгэлтэй байгаа хувьцааны гуравны хоёрыг төрийн мэдлийн хувьцаа эзэлж байна. Тиймээс төр өөрийн өмчөө биржээр хувьчлах хэрэгтэй. Томоохон уул уурхайн эрдэс баялагтай стратегийн орд газруудаа хөрөнгийн биржид гаргах улмаар хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэх шаардлагатай.

-Тухайлбал, энэ чиглэлээр ямар ажил хийгдэж байгаа вэ?

-Биржийн шаардлагын дагуу хувьцаа нь их хэмжээгээр төвлөрсөн компаниуд нэмэлт хувьцаа гаргах эсвэл хувьцаагаа задлах ажлыг хийх ёстой. Мөн шинээр хувьцаагаа хөрөнгийн биржид гаргах, IPO хийх компаниудыг дэмжих, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах гээд хийх ажил цөөнгүй байна. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 475 хувьцаат компани байсан. Тэдгээрийг цэгцлэх арга хэмжээг аваад эхэлсэн. Биржийн листийг цэвэрлэх ажил тасралтгүй цааш үргэлжилнэ. Энэ сарын байдлаар манайд үнэт цаас нь бүртгэлтэй 304 компани байгаа. Үүнээс 200 нь хөрөнгийн биржийн арилжаанд оролцож байна.

-Санхүүгийн зах зээлийн дунд болон урт хугацааны төлөв байдлыг та хэрхэн харж байна вэ. Одоогийн эрчээрээ явбал бидний хүсэд буй зах зээл хэр ойрхон байна уу?

-Санхүүгийн зах зээлийн 95 орчим хувийг банкны систем бүрдүүлж байна. Үүнийг банк давамгайлсан тогтолцоо гэж нэрлээд байгаа. Сүүлд нэг судалгааны байгууллагын хийсэн тооцооллоор банкны салбар 90 орчим хувийг эзэлж байсан гэсэн үр дүн гарсан байна лээ. Бидний хувьд ямар системийг банк давамгайлсан тогтолцоо гэж хэлээд байгаагаа эргэж харах л хэрэгтэй. Гол нь тэнцвэртэй, олон тулгуурт санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх нь чухал байна. Хөрөнгийн зах зээл болон даатгалын систем нь хөгжсөн олон тулгуурт санхүүгийн бүтэцтэй болох ёстой.

Сүүлийн үеийн статистик судалгаа үзэхэд манай зохицуулалтад байгаа салбарын эдийн засгийн үзүүлэлтүүд дандаа өссөн дүнтэй гарсан. Энэхүү өсөлт сүүлийн 10 жил үргэлжилж буй. Даатгалын салбарын бүх үзүүлэлт ч өссөн. Дандаа ашигтай гарсан. Банк бус санхүүгийн байгууллагынх ч мөн адил. Амжилттай яваа салбараа дэмжихийн сацуу сул хөгжсөн хөрөнгийн зах зээлээ ч хөгжүүлэх ёстой. Ингэснээр зах зээл тэнцвэржинэ. Санхүүгийн зах зээлийн хөгжил олон зүйлээс хамаардаг. Тухайлбал, иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах шаардлага ч энд байна. Хорооны зүгээс иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах хүрээнд Азийн хөгжлийн банк болон бусад байгууллагуудтай хамтраад зорилтот төсөл хэрэгжүүлж байгаа.

Банкууд даатгалын зуучлалын үйл ажиллагаа болон кастодианы үйлчилгээний эрх авахаар хандах болсон. Өөрөөр хэлбэл, хорооны зохицуулалтад банкны салбар орж ирж байна.

Үүнээс эерэг үр дүн гарна гэж хүлээж байна.

Төрийн өмчит компаниудыг биржээр хувьчлах нь өгөөжтэй

-Хөрөнгийн зах зээл дэх ихэнх компаниудын хувьцаанд хэт төвлөрөл явгдаж, тэдгээр хувьцаа цөөн хэдэн хүний мэдэлд шилжсэн. Энэ нь үнэт цаасны зах зээлд зогсонги байдал үүсгэх болсныг тус зах зээлийн оролцогчид хэлдэг.

-Аливаа улсын хөрөнгийн бирж өөрийн гэсэн бүртгэлийн шалгууртай. Манай хөрөнгийн биржийн шалгууртаар бол тухайн биржид бүртгэлтэй нээлттэй компанийн нийт хувьцааных нь 25 хувь олон нийтэд арилжаалагдаж байх ёстой. Гэтэл тийм биш. Манай компаниудын дийлэнх нь гэр бүлийн шинж чанартай болсон. Хөрөнгийн захад оролцох идэвх сонирхол нь ч сул. Хувьцааны төвлөрөл нь 80-90 хувьтай компаниудад биржийн дээрх шаардлагыг хангаж ажиллах учиртай.

Компаниуд нэмэлт хувьцаа гаргах эсвэл арилжаагаа идэвхжүүлэхийн тулд хувьцаагаа задлах, хуваах асуудал гарч ирнэ. Дараа нь бүтээгдэхүүн нийлүүлэлтэд анхаарах хэрэгтэй. Төрийн өмчит компаниудыг хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах нь засаглалаа бодсон ч илүү өгөөжтэй. Үүнд төрийн зүгээс ач холбогдох өгөх нь чухал. Ил тод, нээлттэй компанийн давуу тал нь хөрөнгө оруулалт татах боломж бүрддэг. Тухайн компани биржид бүртгэлтэй, олон нийтэд хувьцаагаа арилжаалах сонирхолтой байгаа бол биржийн шаардлагыг хангах ёстойг дахин хэлье.

-СЗХ-ны дэргэд Маргаан таслах зөвлөл байгуулагдсан. Зөвлөл ямар асуудлыг шийдэх вэ?

-Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу хорооны дэргэд Маргаан таслах зөвлөл байгуулагдсан. Бидний хувьд санхүүгийн зах зээлд мэргэжлийн арбитар бий болгох зорилготой ажиллаж байна. Оролцогч талуудын хооронд үүссэн маргаан эцэс төгсгөлгүй шүүхээр явдаг. Үүнийг нэг мөр шийдэх үүднээс дээрх арга хэмжээг авсан. Маргаан таслах зөвлөлийн дүрэм журам гарч, гишүүдээ сонгосон. Зөвлөл нь манай зохицуулалтын байгууллага болон зах зээлийн оролцогч нарын хоорондын маргаантай асуудлыг шийдэх юм. Түүнээс хороотой маргасан асуудлыг үүгээр шийдэхгүй. Тухайлбал, Үнэт цаас, төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв, Хөрөнгийн биржийн Брокер диллерийн компаниуд хооронд маргаан үүсвэл тус зөвлөлөөр асуудлыг шийдүүлнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнд манай хорооны төлөөлөл орж байгаа. Зах зээлийн оролцогч болон хөндлөнгийн судлаач, шинжээчид ч мөн багтсан. Долоон хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлийг манай ажлын албаны дарга ахалж байгаа.

-Сүүлийн үед “Монел”, “Улаанбаатар” зэрэг цөөнгүй хувьцаат компаниудын үнэт цаасыг бүртгэлээс хассан. Үүнийг цэвэрлэгээ хийгдэж байна гэж ойлгож болох уу?

-Одоогийн зах зээл нь биржид бүртгэлтэй байгаа компанийг хүчээр барьдаг тогтолцоо биш юм. Харин сайн засаглалтай, ногдол ашгаа тогтмол тараадаг, ил тод үйл ажиллагаа явуулдаг, зах зээлд идэвхтэй оролцдог, арилжаа нь идэвхтэй зах зээл байх ёстой. Зах зээл ном ёсоор буюу сонгодог байдлаар ажиллах цаг нь ирсэн. Хасагдаж буй компаниудын тухайд хувьцааны төвлөрөл нь 90 хувиас давсан, арилжаа нь зогссон, ямар ч арилжаа байхгүй, өмчийн эзэд буюу хувьцаа эзэмшигчид нь өөрсдөө энэ зах зээлээс гаръя гэсэн санал оруулж ирээд гарч байна. Бид үүнийг хуулийн хүрээнд нь хянаад асуудлыг шийдвэрлэсэн. Дээр нь олон брокер диллерийн компаниудын зөвшөөрлийг хүчингүй болголоо.

“Эрдэнэс Тавантолгой”-н 1072 ширхэг хувьцааг эзэмшүүлэхтэй холбоотойгоор борооны дараах мөөг шиг брокерын

> Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу хорооны дэргэд Маргаан таслах зөвлөл байгуулагдсан. Бидний хувьд санхүүгийн зах зээлд мэргэжлийн арбитар бий болгох зорилготой ажиллаж байна.

компаниуд өөрсдийн зах зээлийн эрсдэлийг тооцохгүйгээр байгуулагдсан. Одоо арилжаа идэвхгүй байгаа үед өөрсдөө үйл ажиллагааны зардлаа дийлэхгүй хүнд байдалд орцгоож байна. Зарим нь арилжаа хийхгүй бүтэн жилээр явсан учраас хуулийн шаардлагын дагуу нэг хэсгийнх нь зөвшөөрлийг хүчингүй болгосон. Нэг үе брокерын компанийн тоо 90 хүрч байсан бол одоо 60 болж буурсан. Хаалттай болж буй компаниудын хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээгүй, өмчийн эзэд өөрсдөө хаалттай болъё гэсэн хүсэлт манайд гаргасан учраас асуудлыг нь шийдсэн. Түүнээс хороо хүчээр хаалттай болгох, арилжааг зогсоох, татан буулгахгүй.

Кастодианы үйлчилгээ үзүүлнэ гэдэг маш өндөр хариуцлага

-Үнэт цаас, төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв /ҮЦТТТХТ/ хэрхэн шинэчлэгдэх вэ?

-ҮЦТТТХТ-ийн хувьцаа эзэмшигч нь Төрийн өмчийн хороо байсан. Засгийн газрын шийдвэрээр бүтцийн өөрчлөлт хийгдэж, хувьцаа эзэмшигчээр нь Сангийн яамыг томилсон. Хоёрдугаарт, ҮЦТТТХТ-ийг хоёр компани болгож хуваах шийдвэр гарсан. Гэхдээ энэхүү шийдвэрт эргэж харах шаардлага бий. Манай хорооны дэргэдэх Үнэт цаасны бодлогын зөвлөл дээрх асуудлаар нэлээд сайн хэлэлцээд өөрсдийн зөвлөмжөө Сангийн яам болон Засгийн газарт хүргүүлсэн. Үнэт цаас, төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс Хадгаламж бүртгэлийнх нь байгууллагыг тусад нь гаргаж байгаа. Төлбөр тооцооных нь асуудлаар тусдаа хуулийн этгээд байгуулах асуудал яригдсан. Төлбөр тооцооных нь хувьцаа эзэмшигчээр Хөрөнгийн биржийг сонгосон байсан. Төлбөр тооцооны асуудал өөрөө зардал ихтэй байдаг. Үүнийг дан ганц Хөрөнгийн биржийн төлбөр тооцооны төв гэхгүйгээр хөдөө аж ахуйн биржийн төлбөр тооцоо хийдэг, биржийн бус зах зээл үүсэх юм бол түүний тооцоог ч мөн хийхээр хуульчлах хэрэгтэй. Нэг ёсондоо хувьцаа эзэмшигч нь ганц хөрөнгийн бирж биш энэ талын үйлчилгээ авч байгаа хэн ч үүнд оролцох боломжтой хувилбар дэвшүүлж байгаа.

-“Голомт” болон “Худалдаа хөгжлийн банк” кастодианы үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан. Цаашдаа бусад арилжааны банкуудад кастодианы үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох уу?

-Хуулийн хүрээнд нээлттэй. Гэхдээ энэ нь өндөр хариуцлагатай үйлчилгээ. Дурын нэг банк аваад хийж чаддаггүй юм билээ. Гадаадад ч гэсэн нөхцөл нь хатуу. Яагаад гэвэл үүнийг дагасан компанийн үйл ажиллагаатай холбоотой үүрэг хариуцлагын асуудал гарч ирдэг. Үнэт цаасыг хадгалах, ногдол ашгийг хуваарилах, төлбөр тооцоог гүйцэтгэх гээд олон талт үйл ажиллагаатай. Арилжааны банкны үйл ажиллагаанаас огт тусдаа учраас үүнийг их хариуцлагатай явуулах ёстой. Надад байгаа мэдээллээр уг зөвшөөрлийг мөн ХААН банк авахаар материалаа ирүүлсэн гэж сонссон. Зах зээл нь үнэт цаасны зах зээл дээр суурилагдсан бүтээгдэхүүн үйлчилгээ

учраас шалгуур хангасан, санхүү болоод боловсон хүчний хувьд нэлээд сайн бэхжсэн банкууд авах ёстой.

-Ирэх оны эхээр Хөрөнгө оруулалтын хоёр сан байгуулагдах гэж байгаа гэсэн. Мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагч бий болж байгаа нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд ямар нөлөө үзүүлэх вэ?

-Хуулийн дагуу хөрөнгө оруулалтын менежментийн компани үүсгэн байгуулагдахаар манайхаас хоёр компани зөвшөөрлөө авсан. Тэд цаанаа хөрөнгө оруулалтын сан байгуулах зорилготой байгуулагдаж байгаа. Эхнийх нь аваад эхэлсэн учраас дараагийнх нь хүсэлтээ тавих байх гэж харж байна. Хөрөнгө оруулалтын сангийн хуулиар нээлттэй сангууд нь тусгай зөвшөөрөл авах, хааттай сангууд нь бүртгэлээр явна гэж хуульчилсан. Ер нь харьцангуй чөлөөтэй эрх зүйн орчныг тавьж өгсөн. Хамгийн гол нь үнэт цаасны зах зээлийн оролцогчид мэргэжлийн байгууллагад хандвал сайн. Хоёрдугаарт, мэргэжлийн сангууд орж ирэх юм бол тэдгээр нь тодорхой зорилготой, сайн судалгаатай зах зээлд оролцдог учраас энэ нь зөв жишиг тогтооно. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу оролцогчдын мөнгө кастодиан банкинд байршина. Энэ нь цаанаа гадаадын хөрөнгө оруулалтыг татах томоохон дэд бүтцийн асуудлыг шийдэж буй юм. ■

БИЧИЛ САНХҮҮ

ИРГЭДИЙН ЗЭЭЛИЙН “ХЭТЭВЧ”



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

351 банк бус санхүүгийн байгууллага 489.9 тэрбум төгрөгийн активтай үйл ажиллагаа явуулж байна.

С.ЗАЯА

Банк мөнгөтэй, барьцаа хөрөнгөтэй хүнд зээл өгдөг. Харин банк бус санхүүгийн байгууллага банкны босго даваагүй, бичил, жижиг бизнес эрхлэх болон хэрэглээний зээлийн хэрэгцээ гарсан хүмүүст харьцангуй уян хатан нөхцөлөөр зээл олгодог газар юм. Гэхдээ банкны том зээлийг бодвол бага хэмжээтэй байдаг. Өөрөөр хэлбэл, бага, дунд орлоготой иргэдийн хамгийн их ханддаг газар нь банк бус санхүүгийн байгууллага болжээ. Автомашин барьцаалсан зээл олгоод, тухайн зээлдэгчид машиныг нь унуулаад явуулж байна. Ингэхдээ тухайн автомашинаа банк бус санхүүгийн байгууллагынхаа нэр дээр шилжүүлээд, даатгуулаад явж байх жишээтэй.

Гэхдээ орон нутагт энэ төрлийн үйлчилгээ харьцангуй сул аж. Тиймээс бид энэ чиглэлийн мэдлэг, мэдээллийг иргэдэд олгох үүднээс уг сэдвийг хөндөж байна.

УИХ-аас 2002 онд Банк бус санхүүгийн байгууллагын үйлчилгээний тухай хуулийг баталжээ. Харин үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгодог. Банк бус санхүүгийн байгууллага зээлийн, цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйлгээ болон итгэлцэл, төлбөрийн баталгаа гаргах, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, зөвлөгөө өгөх зэрэг 10 төрлийн үйлчилгээ явуулж байна. Тэд өөрийн хөрөнгөд тулгуурлаж үйл ажиллагаа явуулдгаараа бусдаас онцлогтой. Өөрөөр хэлбэл, нийт эргэлтийн хөрөнгийнх нь 60-70 хувь нь өөрийнх байдаг. Энэ оны гуравдугаар улирлын байдлаар 351 банк бус санхүүгийн байгууллага 489.9 тэрбум төгрөгийн активтай үйл ажиллагаа явуулж буй. Үүнээс хамгийн их активтай ▸▸

нь 15 байгууллага аж. Энэ нь нийт банк бус санхүүгийн байгууллагын эргэлтийн хөрөнгийн 60 хувийг бүрдүүлж байна. Товчхондоо, дээрх байгууллагуудын зээлийн өрийн үлдэгдэл 293.9 тэрбум, нийт олгосон зээлийн 87.4 нь хэвийн, 6.6 хувь нь хугацаа хэтэрсэн, 6,1 нь чанаргүй зээл байгаа юм. Нийт 518.6 мянган харилцагчтай. Томоохон эргэлтийн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагууд салбар нээх боломжтой аж. Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан судалгаагаар энэ оны гуравдугаар улирлын байдлаар 81 банк бус санхүүгийн байгууллага салбартай байгаа юм.

Иргэд банкнаас зээл авахын тулд нэлээд уддаг. Харин банк бус санхүүгийн байгууллага маш хурдан шуурхай үйлчилдэг аж. Ингэхдээ иргэдийн барьцаа хөрөнгийг банкнаас харьцангуй дээгүүр үнэлдэг байна. Гэхдээ шуурхай байх хэрээр зээлийн хүү нь банкнаас өндөр. Тус байгууллагаас хамгийн их үзүүлдэг үйлчилгээ нь зээл. Үүний дараа валютын арилжаа ордог бол итгэлцэл, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ харьцангуй бага.

Орон нутагт хүрээгээ тэлэх шаардлага бий

Банк бус санхүүгийн байгууллага хаалттай бонд гаргаж болдог байна. Өөрөөр хэлбэл, хувьцаат компаниуд хөрөнгийн биржид нээлттэй IPO гаргадаг бол дээрх байгууллагынхан өөрийнхөө танилын хүрээгээр дамжуулан аль нэг компани, иргэнд хаалттай бонд гаргаж болдгоороо онцлогтой. Санхүүгийн зохицуулах хорооноос бонд гаргах зөвшөөрөл авсан 4-5 байгууллага байгаа аж.

Тус хорооноос банк бус санхүүгийн байгууллагад тусгай зөвшөөрөл өгөхдөө дүрмийн сангийн доод хэмжээг тогтоож өгчээ. Тухайлбал, нийслэлд ийм байгууллага нээхээр зэхсэн бол хамгийн багадаа 400 сая төгрөгийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгөтэй байх ёстой. Харин нийслэлийн алслагдсан дүүрэг болох Багануур, Багахангай, Налайх болон Эрдэнэт, Дархан хотод 200, аймгийн төвүүдэд 50, суманд 20 сая төгрөгийн дүрмийн сангийн босготой. Бичил санхүүгийн байгууллага гэдэг утгаар орон нутагт үйл ажиллагааг нь тэлэхийн тулд хувь нийлүүлсэн хөрөнгийг нь харилцан адилгүй тогтоож өгчээ.


Орон нутагт өнөөдрийн байдлаар 26 банк бус санхүүгийн байгууллага байна. Энэ байгууллагын талаарх иргэдийн мэдлэг хомс байгаа учир Санхүүгийн зохицуулах хороо Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд есөн аймгийн 70 гаруй суманд ажиллаж, хадгаламж зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллагын талаар сурталчлан таниулсан байна. Үүний дараа ийм байгууллага байгуулах хүсэлтэй иргэд олноор санал тавьж эхэлжээ. Энэ талаар Санхүүгийн зохицуулах хорооны Бичил санхүүгийн газрын дарга Н.Оюунчимэг “Орон нутагт 20, 50 сая төгрөгтэй хүмүүс байдаг юм байна. Энэ мөнгөөрөө юу хийхээ мэддэггүй. Бие биенийхээ бизнесийг дуурайгаад хийгээд байдаг. Иргэдэд сурталчлан таниулаад ирэхээр энэ зах зээл рүү орж ирж байна” гэв.

Банк бус санхүүгийн байгууллага эрсдэлээ өөрөө үүрдэг. Итгэлцлийн үйлчилгээ явуулах гэж буй бол Санхүүгийн

Банк бус санхүүгийн байгууллагын ерөнхий мэдээлэл



Банк бус санхүүгийн байгууллагын актив болон нийт зээлийн дүн (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

зохицуулах хорооноос тавьдаг нарийн шалгуур үзүүлэлтийг хангах ёстой. Мөн тухайн итгэл үзүүлэгч иргэн эрсдэлээ давхар үүрдэг аж. Энэ бол хадгаламж биш. Хороо санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс зааварчилга гаргаж явдаг байна. Тухайлбал, зохистой харьцааг тавьж өгдөг. Энэ үзүүлэлтээ хэрхэн хангаж буйг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн улирлын тайлангаас хардаг байна.

ББСБ-ыг цэгцлэхэд шинэ хууль хамгийн чухал

Олон улсад даатгал, хадгаламж зээлийн хоршоо зэргийг багтаагаад нийтэд нь банк бус санхүүгийн байгууллага гэж нэрлэдэг аж. Харин манайд банк бус санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагаа ийн нэрлэсэн нь гадаадынханд ойлгомжгүй байх нь бий гэнэ. Япон, Солонгост манайд байгаа шиг байгууллагаа зээлийн үйлчилгээ үзүүлдэг газар гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл, манайд банк бус санхүүгийн байгууллага гэсэн нэрэн дор 10 төрлийн үйлчилгээ явуулж байна. Харин бусад улсад тус тусад нь салгаж, ангилсан

байх жишээтэй. Зах зээл хөгжих тусам тус салбарын хуулийг шинэчлэх шаардлагатай болжээ. Тиймээс Санхүүгийн зохицуулах хорооноос шинэ хуулийн төсөл боловсруулж, Засгийн газраас санал авахаар хүргүүлсэн байна. Гэсэн ч энэ асуудал Засгийн газрын хуралдаанаар орохгүй удаа дараа хойшилсоор буй гэнэ.

Шинээр боловсруулсан хуулийн төсөлд банк бус санхүүгийн байгууллагыг дотор нь гурван бүлэгт хуваахаар болжээ. Ингэхдээ гадаад валют, зээлийн үйлчилгээ, санхүүгийн байгууллага гэж ангилж. Бүлэг тус бүрт дүрмийн сангийн хэмжээ, шалгуур үзүүлэлт харилцан адилгүй байх юм байна. Тэгэхээр тухайн тогтоож өгсөн бүлгийнхээ хүрээнд л байгууллагууд үйл ажиллагаагаа явуулна гэсэн үг. Сүүлийн хоёр жилд банк бус санхүүгийн байгууллагын тоо 200-гаар нэмэгдсэн байна. Өмнө нь тус байгууллагад харилцагчдын тоо 40-50 мянгаар хязгаарлагддаг байсан бол өдгөө 10 дахин нэмэгдэж 500 мянган харилцагчтай болжээ.

Дээрх байгууллагад тогтоосон дүрмийн сангийн хэмжээ бага байгаа аж. Хууль гарсны дараа хэмжээг нь шинэчлэн тогтоох юм байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос банк бус санхүүгийн байгууллага олноор байгуулагдаж буй нь энэ салбарын нэр хүндийг унагах, зах зээлийг эрсдэлд оруулах сөрөг нөлөөтэй учир үүнд тавих дүрмийн санг нэмж өгөөч гэсэн хүсэлт тавьж байгаа аж.

Гэсэн ч хорооны хуралдаанаас хууль гартал азнахаар шийдээд байгааг Н.Оюунчимэг дарга хэлсэн. Мөн тэрбээр “Шинэ хууль батлагдсанаар санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, банк бус санхүүгийн байгууллагын цар хүрээ нэмэгдэхээс гадна зохицуулалтыг уян хатан болгож өгөх юм. Дээрх үйлчилгээний хүрээнд тохирсон зохицуулалт, хяналт, хязгаарлалтыг бий болгоно” гэв.

Одоогийн хуулиар зээлийн болон валютын үйлчилгээ давхар эрхлэхээр бол хоёр тусгай зөвшөөрөл авч байгаа. Шинэ хуулиар банк бус санхүүгийн байгууллага гэсэн нэг л тусгай зөвшөөрөл өгөх юм. 2006 онд 132 банк бус санхүүгийн байгууллага байсан бол энэ оны гуравдугаар улирлын байдлаар 351 болж нийт эргэлтийн хөрөнгө нь 10 дахин нэмэгдсэн байна. Энэ нь банкны салбарын нийт активын 2.7 хувийг эзэлж буй юм. Мөн 2006 онд дүрмийн сангийн хэмжээ 25.6 тэрбум төгрөг байсан бол 2014 оны гуравдугаар улирлын байдлаар 234.4 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт дүрмийн сангийн 58.7 хувийг эзэлж байна. Хэдийгээр санхүүгийн салбарт өөрийн орон зайгаа өргөжүүлж байгаа ч банк бус санхүүгийн салбарын хууль эрх зүйн орчинг яаралтай шинэчилж, олон улсын жишигт нийцүүлэх, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх нь чухал байгаа юм. ■

БИЧИЛ САНХҮҮ

ТООНООС ЧАНАРТ ШИЛЖИЖ ЭХЭЛЖЭЭ

С.АЗ

Хадгаламж зээлийн хоршоо банк бус санхүүгийн байгууллагаас ашгийн төлөө бус гэдгээрээ ялгаатай. Өөрөөр хэлбэл, сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, өөрсдөө хөрөнгөө гаргаж, нийгэм соёл болон эдийн засгийн хэрэгцээг хангадаг байгууллага юм. Дэлхий нийтэд хадгаламж зээлийн хоршоонд есөн зарчим баримталдаг. Энэ зарчим манайд ч үйлчилдэг. Тодруулбал, сайн дурааараа нэгдсэн байх, бусад хадгаламж зээлийн хоршоотой хамтран ажиллах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, гишүүдийн эдийн засгийн оролцоо, шударга хуваарилалт, хараат бус, бие даасан байдал зэргийг ханган үйл ажиллагаагаа явуулах ёстой.

Энэ зарчмаа алдагдуулж, өндөр хүү амалж, өөрсдийнхөө төлөө ажилласнаар 2005 онд хадгаламж зээлийн хоршоод



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

“Хадгаламж зээлийн хоршоодын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл хэрэгжиж байна.

олноороо дампуурч, олон хүн хохирч, албан тушаалтны амь нас хохирсон гашуун түүх бий. Энэ үеэс монголчуудын хадгаламж зээлийн хоршооонд итгэх итгэл алдарсан. Тэгвэл өнгөрсөн найман жилийн хугацаанд хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаа сайжирсан уу. Сайжирсан бол хэрхэн шинэчлэгдэж өөрчлөгдсөн бэ гэдгийг сонирхоё. 2005 онд улсын хэмжээнд 900 гаруй хадгаламж зээлийн хоршоо бүртгэлтэй байв. Харин өнгөрсөн оны эцэс гэхэд энэ тоо 141 болж цөөрөөд буй. Хоршоодын актив 2013 оны эхний хагас жилийн байдлаар 71.8 тэрбум төгрөг байсан бол жилийн дараа 76.8 болж өссөн байна.

Тус байгууллага өөрийн гишүүддээ хадгаламж, зээлийн болон санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлж, гишүүдийнхээ төлөө үйлчилдэг, ашгийн бус байгууллага бөгөөд дэлхийн улс орнуудад янз бүрийн нэршилтэйгээр үйл ажиллагаа явуулдаг байна. Ингэхдээ гаднаас санхүүгийн эх үүсвэр хайхгүйгээр гишүүдийнхээ хадгаламжийг нэг дор хуримтлуулж, хуримтлалаасаа зээл олгодог. Түүнчлэн гишүүддээ өндөр хүүтэй хадгаламж, бага хүүтэй зээлийн үйлчилгээг санал болгодгоороо онцлогтой аж. Мөн гишүүдийнхээ өдөр тутмын амьдралд хэрэгцээтэй зүйлсийг санхүүжүүлэхэд чухал үүрэгтэй оролцдог гэх. Тухайлбал, жижиг бизнес болон газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэх, ферм байгуулах, хувийн орон сууцаа тохижуулах, хүүхдүүдийнхээ боловсролыг дээшлүүлэх зэрэгт санхүүгийн туслалцаа үзүүлдэг аж.

УИХ-аас 2011 оны аравдугаар сарын 27-нд Хадгаламж зээлийн хоршооны тухай хуулийг баталсан. Хадгаламж зээлийн хоршоо байгуулах тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгодог. Хорооноос зөвшөөрөл аваагүй, түдгэлзүүлсэн тохиолдолд үйл ажиллагаа явуулахыг хуулиар хоригложээ. Мөн гишүүн бус этгээдэд зээл олгох, мөнгөн хадгаламж татах хориотой. Шинэ хуулиар Хадгаламж зээлийн хоршоо үндсэн үйл ажиллагаанаас гадна бусад ажлыг хийж болно гэж заасан. Тэр нь төсөл хөтөлбөрөөр дэмжүүлэн зээлдүүлэх үйл ажиллагаа аж. Мөн санхүүгийн түрээс болон цахим мөнгөний, даатгалын үйлчилгээ явуулж байна.

Хууль батлагдсаны дараа Санхүүгийн зохицуулах хороо 2012 оноос Азийн хөгжлийн банкны шугамаар Японы Засгийн газрын Ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламжаар “Хадгаламж зээлийн хоршоодын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл хэрэгжүүлж эхэлжээ. Энэ хүрээнд хоршоодын үнэлгээний системийг тогтоож, чадавхийн үнэлгээг хийжээ. Ингэснээр хадгаламж зээлийн хоршооны хэмжээнд хийх зайны, танхимын сургалтын модулийг бий болгосон гэж Санхүүгийн зохицуулах хорооны Бичил санхүүгийн газрын дарга Н.Оюунчимэг хэлсэн. Тэрбээр “Төслийн хүрээнд сургагч багш болон үнэлгээчдээ бэлтгэсэн. Нийт 39 удаагийн сургалтаар 1000 гаруй сонгуульт ажилтныг бэлтгэсэн байна. Хууль батлагдсаны дараа есөн журам боловсруулж гаргалаа. Манай Хороо





Өнөөгийн ХЗХ-дын мэдээлэл (2013 оны 4-р улирлын байдлаар)

Бүлгийн дугаар	Бүлэглэсэн активын интервал	Бүлэгт багтах ХЗХ-н тоо	ХЗХ-нд эзлэх хувь	Нийт активт эзлэх хувь	Үүнээс	
					УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ын тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ын тоо
Бүлэг-1	50,0 сая төгрөг хүртэл	58	41,1%	1,8%	17	41
Бүлэг-2	50-500,0 сая төгрөг	68	48,3%	15,4%	29	39
Бүлэг-3	500,0-1,0 тэрбум төгрөг	5	3,5%	4,9%	2	3
Бүлэг-4	1,0 тэрбумаас дээш	10	7,1%	77,9%	9	1
Нийт дүн	141	100%	100%	57	84	

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

зайны хяналт болон газар дээрх шалгалтаа байнга хийдэг. Мөн эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх бэлтгэлээ хангаж байна. Түүнчлэн ХЗХ-д жилийн эцсийн орлогоосоо нөөц сан, хадгаламж хамгаалалтын сан, тогтворжуулалтын сан байгуулж эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлөө бүрдүүлж байгаа" гэв.

2006 онд 51 хадгаламж зээлийн хоршоо байсан бол өнгөрсөн хугацаанд 210 болтол нэмэгджээ. Үүнээс тусгай зөвшөөрлийн шаардлага хангаагүй үндэслэлээр болон өөрсдийнхөө санаачилгаар татан буугдсаар өдгөө 141 болоод буйг дээр дурдсан. Хэдийгээр хадгаламж зээлийн хоршооны тоо буурсан ч гишүүдийнх нь тоо нэмэгдсээр иржээ. Тодруулбал, энэ оны гуравдугаар улирлын байдлаар 28750 гишүүнтэй байна. Үүнээс хоршоонд итгэх иргэдийн итгэл сайжирсныг харж болно хэмээн холбогдох албаны хүн яриандаа онцолсон.

Мөн энэ оны гуравдугаар улирлын байдлаар хадгаламж зээлийн хоршооны гишүүдийн тоо өнгөрсөн оны эцэстэй харьцуулахад гэхэд 5.5, нийт активын хэмжээ есөн хувиар өссөн байна. Түүнчлэн актив 80.8 тэрбумд хүрсэн бөгөөд 77.2 хувийг зээлийн багц эзэлж байгаа юм. Зээлийн чанарыг авч үзвэл, нийт зээлийн үлдэгдлийн 94.5 хэвийн, 2.7 хувь нь хугацаа хэтэрсэн байгаа бол чанаргүй зээл 2.8 хувийг эзэлж байна. Харин хоршоодын хадгаламжийн хэмжээ гуравдугаар улирлын байдлаар банкны салбарын 0.6 хувийг эзэлж байна. Үүнээс нийт мөнгөн хадгаламжийн 97 хувь нь хугацаатай, үлдсэн хэсэг нь хугацаагүй. Тусгай зөвшөөрөлтэй нийт хадгаламж зээлийн хоршоодын 57 нь нийслэлд байгаа бол 84 нь орон нутаг үйл ажиллагаагаа явуулж байна.

Хадгаламж зээлийн хоршооны талаар иргэдийн мэдлэг мэдээлэл хомс. Тиймээс дээрх төслийн хүрээнд энэ талаарх ойлголтыг иргэдэд өгөх зорилгоор олон нийт болоод гишүүдэд зориулсан зохиомжит нэвтрүүлэг, баримтад кино, гарын авлага, товхимол бэлтгэжээ. Мөн хадгаламж, зээлийн хоршоодын нийтлэг эрх ашгийг хамгаалах, Монголын хадгаламж зээлийн хоршоодын холбоо 2007 онд байгуулагдсан байна. Тус холбоо хоршоодынхоо эрх ашгийг хамгаалахаас гадна төрийн байгууллага болон гадаад харилцаанд холбоодоо төлөөлдөг. Нийт хадгаламж зээлийн хоршоодын 104 нь уг холбоонд гишүүнээр элсчээ.

Одоо Хадгаламж зээлийн хоршоо дампуурна гэсэн ойлголт байхгүй болсон гэнэ. Учир нь, зохицуулалт хяналтад бүрэн хамрагдаж, хөгжлийн дараагийн түвшин рүүгээ шилжээд буй аж. ■



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Зээлийн батлан даалтын сан нь банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргана.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ДАРААЛАЛ

1-р АЛХАМ ЖДҮ эрхлэгч, ААН, иргэн нь батлан даалт хүссэн өргөдлөө зээлийн хүсэлтийн хамт банк, санхүүгийн байгууллагад гаргана

2-р АЛХАМ Банк, санхүүгийн байгууллага нь зээл олгох дүгнэлтээ Зээлийн батлан даалтын санд ирүүлнэ




4-р АЛХАМ Банк, санхүүгийн байгууллага нь батлан даалттай зээлийг олгоно

3-р АЛХАМ Зээлийн батлан даалтын сан нь батлан даалт гаргах шийдвэрээ банк, санхүүгийн байгууллагад хүргүүлнэ

Зээлийн батлан даалтын сан нь 284 иргэн, ААН-д батлан даалт гаргажээ

2013 оны эцсийн дүнгээр бизнес регистрийн санд бүртгэлтэй 99603 аж ахуйн нэгжээс идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 44854 нь жижиг, дунд үйлдвэрийн ангилалд хамаардаг. Зээлийн батлан даалтын сангаас хэрэгжүүлсэн “ЖДҮ-500” судалгаанаас үзэхэд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн 91 хувь нь арилжааны банкнаас зээл авах хүсэлтэй байдаг бөгөөд түүнээс 84 хувь нь барьцаа хөрөнгийн дутагдалтай байдаг. Энэхүү хэрэгцээ шаардлагад үндэслэн Зээлийн батлан даалтын сан нь үйл ажиллагаагаа эхэлснээс хойш жил гаруйн хугацаанд жижиг, дунд үйлдвэр эрхлэгч 284 иргэн, аж ахуйн нэгжид 18.6 тэрбум төгрөгийн батлан даалтыг 45.2 тэрбум төгрөгийн бизнесийн зээлд гаргаад байна. Үүний үр дүнд 910 ажлын байр шинээр бий болж, 2196 ажлын байрыг хадгалагдах нөхцөл бүрдэжээ. Мөн нийт батлан даалтын 37 хувийг орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид эзэлж байна.


Батлан даалтын мэдээ (өссөн дүнгээр)




Гаргасан батлан даалтын тоо (эх үүсвэрээр)



Гаргасан батлан даалт /Орон нутгаар/



Гаргасан батлан даалт /банкаар/





Д.Түвдэнням /“Best shoes” ХХК-ийн захирал/:

-Итали, Герман, Чех улсад үйлдвэрлэсэн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг худалдан авч, үйлдвэртээ хөрөнгө оруулалт хийх зорилгоор зээл авахдаа Зээлийн батлан даалтын сангаар батлан даалт гаргуулсан. Бид өнөөдөр дэлхийн стандартад нийцсэн тоног төхөөрөмжийг нэвтрүүлснээр өдөрт 500-800 хос гутлыг үйлдвэрлэх конейверын шугам суурилууллаа.



Я.Эрдэнэбаяр /“Түмэн сүйх” ХХК-ийн Ерөнхий захирал/:

СХД-ийн 21-р хорооны Жаргалант тосгонд 10 га газар авч тэндээ 5280 ам.метр талбай бүхий дэвшилтэт техник, технологитой өвлийн шилэн хүлэмж барьж ашиглалтад оруулсан юм. Үүнд нэлээд их хэмжээний зээлийн эх үүсвэр шаардагдаж энэ дагуу “Голомт” банкинд хандсан ч барьцаа хөрөнгөө нэмэгдүүлж байж хүссэн зээлээ авахаар байсан нь биднийг Зээлийн батлан даалтын санд хандахад хүргэсэн. Ингэснээр манай компанид 250 сая төгрөгийн барьцаа хөрөнгөнд батлан даалт олгогдсон юм.

ТАНИЛЦУУЛГА

САНХҮҮГИЙН ЗОХИЦУЛАХ ХОРОО ЯМАР БАЙГУУЛЛАГА ВЭ

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэйгээр 2006 онд байгуулагдсан төрийн байгууллага юм.

Тус Хороо нь хуулийн хэрэгжилт, түүнчлэн өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааныхаа талаарх ажлаа жил тутам Улсын Их Хуралд тайлагнадаг бөгөөд Хорооны үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд Улсын Их Хурал зохих бүтцээрээ дамжуулан хяналт тавьдаг. Мөн үйл ажиллагааныхаа жилийн тайланг Засгийн газар, Монголбанкинд хүргүүлэн ажилладаг.

Хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, түүнийг хөгжүүлэх, зохицуулах, хяналт тавих чиглэлээр өөр хоорондоо уялдсан үйл ажиллагаа явуулах, үр ашгийг нь нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк, Сангийн яамтай хамтран 2006 онд хамтран ажиллах санамж бичиг байгуулж, Төвбанкны тухай хуульд заасанчлан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн бүрэлдэхүүнд багтаж санхүүгийн асуудлаар зөвлөмж дүгнэлт гаргаж УИХ-д хүргүүлэн ажиллаж байна. Санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн тус Хорооны чиг үүрэг нь зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавьж, түүнд учирч болзошгүй эрсдлийг тооцоолж, урьдчилан сэргийлэх зохих арга хэмжээ авахад оршдог.

Хороо нь зохицуулах чиг үүргийн дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд банкны



үндсэн үйл ажиллагаанаас бусад санхүүгийн салбарт баримтлах дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээг тогтоодог.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Хорооны шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаа байдалд хяналт тавьж, дүрэм, журмыг зөрчсөн гэж үзвэл газар дээрх хяналт шалгалт хийж зөрчлийг арилгуулах арга хэмжээг авдаг.

Хороо нь өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэдэг. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, харилцагчийн хооронд гарсан маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий Маргаан таслах зөвлөлтэй. Үүнд үнэт цаасны мэргэжлийн холбоод, болон зохицуулалттай этгээдийн төлөөллийг оролцуулан хараат бус бие даасан байлаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу байгуулан ажиллуулж байна.

Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий Хяналтын зөвлөл, Улсын Их Хурлаас байгуулагдан ажилладаг. Уг зөвлөл нь үйл ажиллагааныхаа тайланг Улсын Их Хуралд дараа оны эхний улиралд багтаан танилцуулдаг.

Хороо нь санхүүгийн зах зээлийн мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор гадаад улсын эрх бүхий зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг болон гэрээ байгуулан ажиллах эрх хэмжээнийхээ хүрээнд Үнэт цаасны хороодын Олон улсын байгууллага /IOSCO/, мөн Олон улсын Даатгалын хяналтын холбооны гишүүн /IAIS/ орон болсноор дэлхийн түвшинд Монгол улсын санхүүгийн салбарын хамтын ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн БНХАУ-ын Үнэт цаасны зохицуулалты

хороо, БНКУ-ын Санхүүгийн зах зээл, санхүүгийн байгууллагын хянах зохицуулалтын агентлаг, Польш улсын Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага, БНСУ-ын Санхүүгийн хяналт шалгалтын хороо, Япон улсын санхүүгийн үйлчилгээний агентлаг, Хонконгийн үнэт цаас, фьючерсийн хороо зэрэг гадаад улсуудын санхүүгийн зах зээлийн хяналт зохицуулалтын байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулаад байна.

Тус Хороо нь үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн зах зээлийн талаар баримтлах стратегийн зорилтуудаа тодорхойлсон “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги \2012-2016\”-ийг 2012 оны 4 дүгээр сарын 22-нд батлан гаргасан.

Энэхүү баримт бичигт Санхүүгийн зохицуулах хороо эрхэм зорилгоо “Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагаа бүхий санхүүгийн салбарыг хөгжүүлэх” гэж тодорхойлсон.

Олон улсын практикт санхүүгийн зах зээлийг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага нь зах зээлийн тогтвортой байдал, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалж, системийн эрсдлийг бууруулах үндсэн зорилготой байдаг бөгөөд тус Хорооны хувьд энэ чиглэлээр өөрийн зохицуулалтын салбарын стратегийг нарийвчлан тусгаж, хэрэгжүүлэх арга замыг тодохойлж өгсөн. Үүнд:

Үнэт цаасны салбарт:

- Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын стандарт, зарчмуудыг мөрдөн хэрэгжүүлэх замаар хууль эрх зүйн орчныг сайжруулж, бэхжүүлэх стратеги;
- Зуучлалын зах зээлийн хувьсал өөрчлөлтийг танин мэдэх стратеги;
- Системийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах стратеги;
- Үнэт цаас гаргагчдын олон улсын тэргүүн туршлагаас суралцах амьдралд хэрэгжүүлэх стратеги.

Даатгалын салбарт:

- Эрсдлийн удирдлагад суурилсан хяналт тавих зураглал гаргах стратеги;
- Санхүүгийн зохицуулах хорооны зарим эрх үүргийг шилжүүлэх боломжтой этгээдийг олж тогтоох стратеги.

Бичил санхүүгийн салбарт:

- Хүртээмжтэй санхүүгийн салбарын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бичил санхүүгийн зохицуулалтын загвар боловсруулах стратеги;
- Бичил санхүүгийн газрын чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааг зохицуулдаг хууль эрх зүйн актуудыг боловсронгуй болгох стратеги;
- Эрх шилжүүлэх боломж, нөхцлийн талаар үнэлгээ хийх стратеги.

гэж тус тус тодорхойлон энэ зорилгын хүрээнд зохицуулалтад хамаарагдах дээрхи салбар бүрээр үндсэн үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэн мөрдөн ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь Монгол улсын хууль тогтоомж, олон улсын санхүүгийн зах зээлийн стандарт, зарчмын хүрээнд өөрийн орны өвөрмөц онцлог, эдийн засгийн орчин нөхцөлд тохирсон уян хатан зохицуулалт, хяналтын арга хэлбэрийг авч хэрэгжүүлж байна. Цаашид зах зээлийн олон тулгуурт чөлөөт өрсөлдөөн бүхий, харилцагч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг дээдэлсэн нээлттэй, ил тод бүтцийг бий болгох чиглэлээр бүхий л талаар чармайлт гарган ажиллах болно. ■

ДААТГАЛ

ДАВХАР ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ЭРЭЛД

Б.ТОГТОХ

Улсын хэмжээнд дөрвөн хүн тутмын нэг нь даатгалтай байна

Монголын даатгалын хамгийн анхны байгууллага 1934 онд үүсч байгуулагдсан түүхтэй. Эндээс цаг хугацааг эмхлэх аваас энэ салбар өдгөө 80 насны сүүдэртэйгээ золгож байна. 1990 оны эхэн үе хүртэл төрийн гэх ганцхан компани энэ зах зээлд монополь эрх эдэлж байсан. Энэ нь хуучнаар төрийн өмчит “Монгол даатгал”. Түүнийг хэлбэрийг зах зээлийн эдийн засагт шилжихийн өмнөхөн өөрчилж албан ёсны даатгалын компани болгосон байдаг. Ингэснээр тус компаниас Түшиг болон Хөдөө аж ахуйн даатгалын цоо шинэ компаниуд өрх тусгаарлажээ. Өнөөдөр тус салбарт 17 компани үйл ажиллагаа явуулж, санхүүгийн зах зээлийн нэг хувийг эзлэх хэмжээнд “чөмөг” суужээ. Эдийн засагч Д.Жаргалсайхан “Даатгал нь санхүүгийн зах зээлийн хамгийн том хэсгийг бүрдүүлдэг хөрөнгө юм. Даатгалын хуримтлал нь хөгжсөн орнуудын хөрөнгийн зах ▸▸

зээлийн тулгуур яс, үнэт цаасны арилжааг идэвхжүүлдэг хөшүүрэг болдог” хэмээн “Гамшгийн даатгал” өгүүлэлдээ бичжээ.


Хувийн гэх тодотголтой даатгалын компаниуд нэмэгдэж, зах зээлд улмаар өрсөлдөөн бий болж эхэлсэн нь 1997 он. Энэ үед Монголын анхны Даатгалын тухай хууль батлагдаж, тус салбар өөрийн гэсэн эрх зүйн баримт бичигтэй болсон байдаг. Үүнтэй холбогдуулан Сангийн яамны Даатгалын хяналтын албанаас даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг есөн компани авч байсан аж. Аажмаар тэлж буй даатгалын салбарын “малгай” хууль дахин иж бүрэн “засвар”-т орж, 2004 онд шинэчлэгдсэн. Энэхүү хуулийн дагуу энэ оны гуравдугаар улирлын байдлаар ердийн даатгалын 16, урт хугацааны амьдралын даатгалын нэг компани тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Анхны хууль батлагдаж байх үед даатгалын компанийн дүрмийн санг 100 сая төгрөгөөр тогтоож байж. Тэгвэл өнөөдөр ердийн даатгалын компанийн дүрмийн сан таван тэрбум төгрөгөөр хэмжигдэх болсныг Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга П.Цэрэндэжид дурдаад дүрмийн сангийн хэмжээ 100 сая төгрөгөөс таван тэрбумд хүрсэн нь энэ салбарын хөгжлийн явцыг илтгэх нэг хэмжүүр хэмээн онцлов. Амьдралын буюу урт хугацааны даатгалын компани зургаан тэрбум төгрөгийн дүрмийн сантай байна гэсэн шаардлагыг СЗХ-ноос гаргасан. Мөн давхар даатгалын компанид 15 тэрбум төгрөгийн босго бүхий дүрмийн санг журамлажээ.


Даатгалын салбарт ажиллаж буй компаниас гадна энэ зах зээлд мэргэжлийн оролцогч буюу даатгалын 26 зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч 19 компани үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнээс гадна таны эрсдэлд ногдох даатгалын нөхөн төлбөр, хувь хэмжээг тогтоож байдаг СЗХ-ны зөвшөөрөлтэй 15 актуарч байгаа аж. Актуарч нь даатгалын компанийн хамгийн чухал, нарийн тооцоо судалгааг боловсруулж, түүний тохиргоог хийж байдаг мэргэжилтэн. Дэлхийн түвшинд математик, статистик, магадлалын онолын шинжлэх ухааныг эзэмшсэн актуарч хамгийн өндөр цалинтайд тооцогддог байна. Сүүлийн таван жилийн хугацаанд даатгалын хураамжийн орлого 15-20 хувийн хооронд хэлбэлзэх болжээ. Хураамжийн орлого 2012 онд 64 хувиар огцом өссөн бөгөөд энэхүү өсөлт нь Жолоочийн даатгалын тухай хууль батлагдсантай холбоотойг Монголын даатгагчдын холбооны ерөнхийлөгч Ж.Бат-Орших онцолсон удаатай. Тэрээр үндэсний давхар даатгалын тогтолцоо бий болгох шаардлагатай байгааг үргэлж хэлдэг.

Жолоочийн даатгалын тухай хууль нь Монголд албан журмын даатгалын тогтолцоог шинээр нэвтрүүлсэн төдийгүй анхны албан журмын даатгалын хууль. Энэ утгаараа даатгалын салбарт олон харилцагчдыг дагуулж ирсэн гэж хэлж болохоор. “Зөвхөн даатгал төлөгчдийг нэмэгдүүлээд зогсохгүй иргэдэд даатгалын мөн чанарыг ойлгуулж байгаа бүтээгдэхүүн” гэж Д.Цэрэндэжид тэмдэглэсэн. СЗХ-ноос зарим төрлийн шаардлагатай байгаа албан журмын тухай хуулийн хэд хэдэн төсөл дээр ажиллаж байгаа аж. Үүний нэг нь Эмнэлгийн байгууллагын ажиллагсадын хариуцлагын даатгалын албан журмын тухай хуулийн төсөл. Олон улсын жишгийн дагуу


1
Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөг)



3
Даатгалын компаниудын нөхөн төлбөр (тэрбум төгрөг)



5
Даатгалын хохирлын харьцаа (тэрбум төгрөг)



ойрын жилүүдэд мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгалын шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлэх юм байна.

Даатгалын компаниуд 100 төгрөг тутмын орлогынхоо 40-50 төгрөгийг эргүүлэн нөхөн төлбөрт олгож байгаа гэсэн судалгаа гарчээ. Сүүлийн үед хураамж өсөхийн хэрээр илүү олон даатгагч тус салбарт элссэн байна. Үүнийг дагаад даатгалын хохирлын харьцаа өсөх хандлагатай байгаа аж. Санхүүгийн салбарын нэг хувийг эзлэх хэдий ч амжилттай бөгөөд ашигтай ажиллаж буй бизнес бол даатгал гэдэг. Тус салбарын орлого СЗХ-ны мэдээллээр энэ оны гуравдугаар улиралд 81 тэрбум төгрөгт хүрчээ. Эдийн засгийн ерөнхий өсөлтөө даган тус салбарын орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 20 хувиар өссөн байна. Улсын хэмжээнд нэг хүнд ногдох даатгалын хураамж 32 мянган төгрөг байгаа бөгөөд энэ нь 20 орчим ам.доллартай тэнцэх аж. Энэхүү үзүүлэлт нь хөгжиж буй орнуудад 60-70 ам.доллар байдаг байна. Үүнийг Дэлхийн банкны даатгалын төслийн зөвлөх Б.Заяа “Харьцангуй доогуур үзүүлэлт” хэмээн чамласан.


Иргэдийн орлого сайжрах, эдийн засаг тэлэх, хүмүүсийн амьжиргааны түвшин дээшлэх тусам даатгалын салбарт түүнийг дагасан өсөлт гарч байдаг байна. Үүнээс гадна иргэдийн санхүүгийн боловсролд ахиц гарч, эрсдэлийн талаарх ойлголт нь нэмэгдэх бүрт даатгалд хамрагдах нийтийн сонирхол бодитой илэрдэг аж. Д.Цэрэндэжид “Даатгалын салбарт хөгжих орон зай, зах зээлийн багтаамж байгаа” хэмээсэн.

Дэлхийн банкнаас энэ онд хийсэн “Монгол Улсын даатгалын зах зээл: Өнөөдөр ба ирээдүй” судалгаанд “2020 он гэхэд ДНБ-ий дөрвөн хувийг эзлэх хэмжээнд хүрч 860 гаруй тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой болох бололцоотой” гэсэн өөдрөг төсөөлөл гарчээ. Өдгөө үйл ажиллагаа явуулж буй нийт компанийн хөрөнгийн хэмжээ 126.4 тэрбум төгрөг. Хураамжийн орлого нь 93.9 тэрбум бол хөрөнгө оруулалтын орлого нь 8.3 тэрбум төгрөг гэсэн статистик дүн гарчээ.


Дээрх судалгааны зөвлөмжөөс үзэхэд манай даатгалын компаниуд нэгдэх, хувьцаат компани болох, гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах шаардлагатай байгаа аж. Цаашилбал үндэсний даатгалын компанитай болохын сацуу үндэсний давхар даатгалын тогтолцоог нэвтрүүлэх нь оновчтойг Дэлхийн банкнынхан судалгаандаа онцолжээ. Мөн тус салбарт мэргэжлийн ажиллах хүчний хомсдол байгааг дурдсан байна. Үндэсний давхар даатгалын тогтолцоо гэдэг нь баталгаажсан үнэт цаастай зүйрлэж болохоор. Үүнийг бүрдүүлэхийн тулд давхар даатгалын үндэсний компанийг бий болох ёстой аж.

Нийтлэлийнхээ төгсгөлд нэгэн таатай мэдээг дуулгая. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль энэ онд батлагдсан. Тус хууль гарснаар Хөдөө аж ахуйн давхар даатгалын анхны компани энэ онд байгуулагдах гэж байна. Одоо СЗХ-ноос давхар даатгалын компанийн журмыг боловсруулж байгаа аж. Бэхжиж басхүү хөгжиж яваа даатгалын салбарт эргэлдэх мөнгөн хөрөнгийн хэмжээ нэмэгдэж, санхүүгийн үзүүлэлт нь сайжрах болсныг дээрх тоонууд бэлхэн илтгэнэ. Өөдөлж яваа айлын үүдээр шагайхад ийм байна. ■


2 Даатгалын компаниудын хураамжийн орлого (тэрбум төгрөг)



4 Даатгалын нөөц сан (тэрбум төгрөг)



6 Давхар даатгалын хураамж (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



Хөрөнгө оруулалтын сан бий болж, кастодианы үйлчилгээ нэвтэрснээр хөрөнгийн зах зээл бүрэн бүтэн болно.

МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ ҮГ

Ө.ГАНЗОРИГ: ХӨРӨНГИЙН ЗАХ ХӨГЖИХГҮЙ БАЙХ НЬ ЭРСДЭЛ

Б.БАЯРТОГТОХ

Санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлийн гишүүн Ө.Ганзоригтой ярилцлаа.

-Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлийн зорилго болоод үйл ажиллагааны чиглэлийн талаар манай сэтгүүлийн уншигчдад дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү. Цаашид ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ?

-Монголын эдийн засагт тулгамдаад буй хамгийн чухал асуудал хөрөнгийн захын хөгжил. Хөрөнгийн зах нь эдийн засаг дахь баялгийн зөв хуваарилалтыг хийдэг механизм. Гэтэл хөрөнгийн захын өнөөгийн хөгжлийн явцаас шалтгаалаад эдийн засагт баялгийн зөв хуваарилалт хөндүүр сэдэв болж байна. Энэхүү баялгийн зөв хуваарилалт хийдэг механизмгүйгээр бид цааш явбал Монгол Улсын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлнө. Энэ нь одоогийн нөхцөл байдлыг улам ч муутгах талтай. Хэрэв цөөн хэдэн баян хүнтэй, маш олон ядуу иргэдтэй эдийн засаг төлөвшиж үлдвэл энэ нь их аюултай. Төлөвшсөн эдийн засаг гүн гүнзгий баялгийн хямралд орсон тохиолдолд буцаах боломжгүй. Үүнийг бараг хувьсгал хийж байж эргүүлнэ.

Орчин үеийн чөлөөт зах зээлийн эдийн засагт баялгийн зөв хуваарилалтыг хөрөнгийн зах зээл л хийдэг. Тиймээс Монголд хөрөнгийн зах зээлийн хөгжил маш чухал. Төр, засгийн зүгээс хөрөнгийн зах зээлийн хөгжилд төдийлэн ач холбогдол өгч байсангүй. Харин Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/ энэ зах зээлийн хөгжлийн төлөө зүтгэж байгаа цорын ганц төрийн байгууллага нь. Манай холбоо болон энэ захад оролцогчдын хувьд ч гэсэн хорооны үйл ажиллагааг ойлгож, дэмжиж ирсэн. Хөрөнгийн зах хөгжихгүй байх нь эрсдэл. Тиймээс нэн тэргүүнд хөгжүүлэх шаардлага байгаа.

СЗХ-ны дэргэд Үнэт цаасны зах зээлийн зөвлөл байгуулагдаад удаагүй байна. Зөвлөлийн үндсэн зорилго хөрөнгийн захын хөгжлийг хангах, хөрөнгийн захыг зөв зохистой хөгжүүлэх явдал. Хамгийн гол нь аль болох хурдан хөгжих. Зөвлөлийн зүгээс хөрөнгийн захыг хөгжүүлэхэд юу саад болж байгааг тодорхойлох, ямар бодлогын алхам хийх шаардлагатай байгааг гаргаж ирэх. Бидний зүгээс СЗХ-нд зөвлөх үүрэгтэйгээр ажлаа явуулна. Төлөвлөж буй цөөнгүй ажил бий.

-Зөвлөл хоёр сар тутам хуралдаж

буй. Гэхдээ шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал хийхээр байгаа. Ойрын хугацаанд ямар асуудал хэлэлцэхээр байгаа вэ?

-СЗХ-ноос гаргаж буй хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бодлого, арга хэмжээнд зөвлөл өөрсдийн чиглэл, санал, хүсэлтээ илэрхийлнэ. Бидний санал, зөвлөмж хороогоор дамжаад төр, засгийн түвшинд хүрсэн байгаа. Зөвлөл байгуулагдаад удаагүй ч шуурхай ажиллаж байна. Бид эхний хурлаараа хөрөнгийн захыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудалд анхаарал хандуулах зорилготой зөвлөмж боловсруулсан. Энэ нь хороогоор дэмжигдэн УИХ-д хүрсэн. Өнөөдөр хөрөнгийн зах хөгжвөл бүх зах дагаад хөгжих болно. Тухайлбал, таваарын зах болон мал аж ахуй цэцэглэнэ. Ингэснээр жижиг, дунд үйлдвэрлэл, баялгийн шударга хуваарилалт, ажлын байр, ам.долларын ханш гэвэл маш олон зүйл үүгээр шийдэгдэх юм. Ам.долларын ханш, жижиг дунд үйлдвэрлэлээ хэрхэн хөгжүүлэх зэрэг асуудлаас болоод хөрөнгийн захын хөгжил дарагдах эрсдэлтэй. Бидний зүгээс нэг удаа санал зөвлөмж өгөөд зогсохгүй хойноос нь явах болно. Хөрөнгийн захад оролцох, түүний талаарх зөв мэдээллийг нийтэд түгээх, буруу ойлголтыг арилгах талаар СЗХ-той хамтраад ажиллана. Хадгаламж зээлийн хоршооны хямралтай холбогдуулан олон нийтэд хөрөнгийн захын талаарх ойлголт бүдгэрсэн. Түүнд итгэх итгэл суларсан. Тиймээс ташаа ойлголтыг зөв тийш нь хандуулахад чиглэсэн ажлууд хийх шаардлагатай.

-Монголын үнэт цаасны зах зээлд тулгамдаж буй ямар асуудал байна вэ. Тэр тусмаа хууль эрх зүйн орчинд наштай өөрчлөлт гарсан уу?

-Хөрөнгийн зах зээлтэй холбоотой хэд хэдэн эрх зүйн баримт бичигт шинэчлэл хийгдлээ. Түүний нэг нь Үнэт цаасны тухай хууль шинэчлэгдэн батлагдсан явдал. Мөн үүнтэй холбоотойгоор дагавар хуулиудад ч нэмэлт, өөрчлөлт орсон. Тухайлбал, Даатгалын тухай хуульд өөрчлөлт орсон. Даатгалын компаниуд хөрөнгийн захад өнөөдөр хөрөнгө оруулах боломжтой болсон. Дараагийн бас нэг шинэчлэл бол Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль Монгол Улсын түүхэнд анх удаа шинээр батлагдсан. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотой зохицуулалт, тусгай хуулийн этгээдийн заалтууд ороод сүүлийн 4-5 жилд хөрөнгийн зах зээл дээр хууль эрх зүйн эхний шатны шинэчлэл амжилттай хийгдээд байна.

-Дараагийн шатны шинэчлэл юу байх вэ?

-Тухайлбал, Хувийн тэтгэврийн санг бий болгох эрх зүйн орчинг яаралтай бүрдүүлэх хэрэгтэй байна. Тус сан нь зах зээлд орж ирснээр хөрөнгийн захын хөгжлийг улам түргэтгэнэ. Цаашилбал, баялгийн зөв хуваарилалтын дэд бүтэц тавигдана. Ингэснээр хөрөнгийн зах хөгжих суурь нөхцөл бүрдэх юм. Одоогийн нөхцөлд эрх зүйн орчин тийм

> Сүүлийн гурван жилд хандлага өөрчлөгдөж байна. УИХ-ын гишүүд хөрөнгийн зах зээл чухал гэдгийг ойлгож эхэлсэн. Хорооноос УИХ-д оруулж ирж байгаа хуулийн төсөлд ач холбогдол өгч байна. Энэ бол наштай ололт.

ч таатай сайн биш байна. Гэхдээ бид эхний шатны том ажлын ард гарлаа. Нэг зүйлийг онцолж хэлэхэд, УИХ-ын зүгээс СЗХ-той илүү нягт хамтарч ажиллах учиртай. Өмнө нь зах зээлтэй холбоотой хуульд УИХ-ын гишүүд нэлээд хойрго хандах нь түгээмэл байсан. Хуулийн төслийг СЗХ-той хамтарч боловсруулах, асуудал ч дутмаг явсан. Тэгвэл сүүлийн гурван жилд хандлага өөрчлөгдөж байна. УИХ-ын гишүүд хөрөнгийн зах зээл чухал гэдгийг ойлгож эхэлсэн. Хорооноос УИХ-д оруулж ирж байгаа хуулийн төсөлд ач холбогдол өгч байна. Энэ бол наштай ололт.

-Засгийн газрын үнэт цаас хөрөнгийн биржид бүртгэгдэн арилжигдах боллоо. Энэ нь үнэт цаасны зах зээлийн одоогийн хөгжилд хэрхэн нөлөөлөх вэ?

- Засгийн газрын үнэт цаас 1990 оны сүүлч болон 2000 оны эхээр хөрөнгийн биржэд гарч байсан. Гэхдээ хоёрдогч зах зээлийн арилжаа хийгдээгүй. Тэгвэл одоо хоёрдогч зах зээлийн арилжаа явагдаад эхэлсэн. Хамгийн чухал өөрчлөлт нь тогтмол болж байгаа явдал. Ингэснээр зах зээлд суурь хүү тогтоно. Суурь хүү тогтож байж тухайн эдийн засаг төлөвших, бизнест төлөвлөлт хийх боломжтой болно. Засгийн газрын бондын арилжаа идэвхжүүлж байгаа нь зах зээлийн чухал алхам. Манай зах зээлийн хувьд суурь хүүгүй олон жил явж ирсэн.

-Хөрөнгө оруулалтын сан бий болж байгааг Та хэрхэн харж байна вэ?

-Аливаа улсын хөрөнгийн захын хөгжил хөрөнгө оруулалтын сантай шууд холбоотой байдаг. Тиймээс хөрөнгө оруулалтын санг дагаад кастодианы үйлчилгээ хэрэгтэй болдог. Кастодиан болон хөрөнгө оруулалтын сангийн үндсэн зорилго нь хөрөнгө оруулагчдыг эрхийг хамгаалах. Тэд бол мэргэжлийн тоглогч төдийгүй хөрөнгийн захад оролцогчдод туслах үүрэгтэй. Одоо хөрөнгө оруулагчид өөрсдөө л бие даан хувьцаа, бондоо авч байна. Тэгвэл кастодианы үйлчилгээ нэвтрээд ирэхээр илүү амар болохын зэрэгцээ зах зээлийг ойлгоход ч хялбар болно.

Хөрөнгө оруулалтын сан мэргэжлийн шийдвэр гаргаж байдаг. Үүгээрээ давуу талтай. Манайд ажиллаж буй брокер харилцагчдад зөвлөгөө өгдөг. Брокерын үүрэг баруунд ч, Монголд ч ялгаагүй адил. Энэ үүргээ ч манайхан биелүүлж ирсэн. Энэ зуур сонирхлын зөрчлийн асуудал гарч ирэх тал бий. Гэхдээ үүнийг эрх зүйн системээр хааж өгсөн байдаг.

Брокерын компаниуд хөрөнгийн захын хөгжлийг өдий хүртэл авч явж тодорхойлж ирсэн. Хэдий ийм ч мэргэжлийн оролцогчид үгүйлэгдэж байсан. Хөрөнгийн зах өмнө нь зөвхөн брокерын компаниар төсөөлөгдөж байлаа. Тэгвэл өнөөдөр Хөрөнгө оруулалтын сан гэсэн цоо шинэ институц, Кастодиан орж ирснээр одоо хөрөнгийн зах бүрэн бүтэн болно. Үүний дагуу өмнө нь олон жил брокерын бизнес хийсэн компаниудын ашиг орлого нэмэгдэнэ. Хөрөнгө оруулалтын санг өрсөлдөгч гэж харж болохгүй. Харин зах зээлийн эргэлт сайжирна. Сантай холбогдолтой дагалдах хорооны журам дүрэм ч эцэслэгдэн гарсан. ■



МАСА ИГАТА
/"Фронтиер" ХХК-ийн гүйцэтгэх захирал/

ҮЗЭЛ БОДОЛ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

Юуны өмнө Монголын Үнэт цаасны хороо байгуулагдсаны 20 жилийн ойн мэнд хүргэе. Монголын хөрөнгийн зах зээлийг өнөөгийн түвшинд хүргэхэд зохицуулагч болон зах зээлд оролцогчид өнгөрсөн он жилүүдэд онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн. Гэсэн хэдий ч зах зээлийн хэмжээ жижиг хэвээр байгаа бөгөөд сүүлийн үед хөрөнгийн биржийн үйл ажиллагаа хангалтгүй байна. Мэдээж, эдийн засгийн таагүй нөхцөл сөрөг нөлөө үзүүлж болох. Гэхдээ салбарын зүгээс зах зээлийг хөгжүүлэх тал дээр дорвитой арга хэмжээ авах хэрэгтэй байгаа юм. Доор дурьдсан 10 саналд хөрөнгийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, урагшлах аргуудыг багтаасан болно. 20 жилийн дараах өндөрлөгөөс харахад хөрөнгийн зах зээл дээрх худалдаа илүү идэвхжиж Монголын компаниуд хөрөнгө босгоход чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна. Одоогоор хөрөнгийн зах зээл санхүүгийн эх үүсвэрийн багахан хэсгийг хангаж байна. Учир нь энэхүү зах зээлд банк голлох үүрэгтэй ажиллаж байгаа юм. Уул уурхай, дэд бүтцийн салбарт ихээхэн хөрөнгө шаардагдаж буй энэ үед хөрөнгийн зах зээлийн үүрэг улам чухал болох юм. Учир нь эдгээр салбар дахь мөнгөний урсгал тогтворгүй, иймд банкны санхүүжилт гэхээс илүүтэй хөрөнгийн биржийн схемээр дамжин санхүүжих нь тохиромжтой. Доорх жагсаалтад нэн тэргүүнд шийдвэрлэх 10 зүйлийг тайлбарын хамтаар өгүүлье.

1. Хөрөнгө оруулагчдад мэдлэг, мэдээлэл олгох хөтөлбөрийг нэмэгдүүлэх

Хөрөнгийн зах зээлийн ханшийн хэлбэлзэл их байдаг тул сайтар боловсруулсан хөтөлбөр Монголын нөхцөлд маш чухал байна. Хөрөнгө оруулагчид үнэт цаасны зах зээлтэй холбоотой эрсдэлийг ойлгоогүй цагт хувьцааны үнэ, үндсэн үзүүлэлтүүд уруудах үед хүнд асуудалд орно.

2. Салбар дахь ёс зүйн стандартыг бэхжүүлэх

Хөрөнгийн зах зээл тодорхой дүрмийн дагуу явах хэрэгтэй. Хэрэв тогтоосон дүрмийг зөрчвөөс холбогдох байгууллагын зүгээс хариуцлага тооцох, улмаар тоглогчид хууль эрх зүйн хүрээнд ёс зүйтэй зах зээлд орох ёстой гэдгийг тэдэнд сануулах юм.

3. Зохицуулагч болон зах зээлд оролцогчдын мэргэшүүлэх

Үнэт цаасны зах зээл өдөр болгон хувьсаж байдаг. Өдөр бүр шинэ бүтээгдэхүүн танилцуулагддаг. Иймд тэд, тэр дундаа брокер дилерүүд тухайн бүтээгдэхүүн болон түүний механизмын үндэс суурийг сайтар ойлгож, авч буй мэдээллээ тухай бүрт нь шинэчлэх хэрэгтэй. Ингээгүй тохиолдолд хөрөнгө оруулж буй бүтээгдэхүүний талаар ташаа мэдээлэл авах эрсдэлтэй.

4. Төрийн өмчит байгууллагуудад шинэчлэл хийх

Хөрөнгийн бирж дээр гарахын өмнө төрийн өмчит компаниудад шинэчлэл хийх шаардлагатай тулгардаг. Хөрөнгийн зах зээл дээр гарах ямар утга агуулж буйг өөрсдөөсөө асуух хэрэгтэй юм. Шинэ хөрөнгө оруулагч уриалахаас урьтаж цөөнх хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг биелүүлсэн байх үүрэгтэй гэдгээ ойлгох нь чухал. Түүнчлэн хувьцаа эзэмшигчдэд хангалттай ашиг ногдуулах хэрэгтэй. Иймд хувьцаа эзэмшигчид төрийн өмчит комданиудад чухал бүрэлдэхүүн хэсэг болдог.

5. Монголын хөрөнгийг бирж дээр гарах хүсэлтэй компаниудад урамшуулал үзүүлэх

Ямар ч компани дотоодоос эсвэл олон улсаас санхүүжилт босгож болно. Түүнчлэн хувийн, төрийн санхүүжилт гэсэн сонголт бий. Монголын хөрөнгийн биржэд бүртгүүлэх хүсэлтэй компаниудад урамшуулал үзүүлэх нь зүйтэй. Өмнө нь энэ тал дээр тодорхой зүйл байгаагүй. Монголын хөрөнгийн биржэд бүртгүүлэхийг тулгах нь компаниудыг татах урт хугацааны сайн стратеги биш юм.

Хөрөнгийн зах зээлд өрсөлдөхүйц татварын систем нэвтрүүлэх

Хувьцаа худалдахад ногдуулах татвар бусад олон улсын зах зээлтэй өрсөлдөх хэмжээний чадвартай байх хэрэгтэй. Үнэт цаасны худалдаа, үр ашигт хэт өндөр татвар тооцох байдлыг арилгах эсвэл түр зогсоосноор Монголын зах зээлд оролцох хүсэлтэй хөрөнгө оруулагчдыг дэмжих юм. Мэдээж, эдгээр нь татварын орлогын чухал хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

7. Зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор шинэ схем боловсруулах

Бүртгэлтэй компаниудын нөөцийн үзүүлэлт бага байдаг нь хөрвөх чадвар доогуур байхад нөлөөлдөг. Тиймээс комданиудыг бүртгэлтэй үлдээхийн тулд бүртгэх аргачлалын шалгуур үзүүлэлт тавих хэрэгтэй. Ийнхүү хөрвөх чадвар муудсан нөхцөлд хоёр зах зээл дээр гарах эсвэл бусад арга хэмжээ авч хөрвөх чадвараа сайжруулах боломжтой.

8. Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын засаглал, ил тод байдал, хаалттай бус байдлыг чухалчлах

Өнгөрсөн хугацаанд дээрх ухагдахуун чухал талаар хэд хэдэн удаа яригдаж байсан. Харамсалтай нь биеллээ олсон зүйл одоогоор алга. Тодорхой чиглэл санаачилж, хэрэгжүүлснээр дээрх асуудлууд баталгаажих юм.

9. Мэргэшсэн сангийн менежерүүд хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх

Хөрөнгө оруулалтын итгэлцлийн хууль, шинэ үнэт цаасны зах зээлийн хууль хөрөнгийн зах зээлийн үндэс болдог. Хуулийн тогтоолуудыг албан ёсны болгох хэрэгтэй. Түүнчлэн гадаадын болон дотоодын кастадионд урамшуулал үзүүлэх замаар хамгаалалт нэвтрүүлэх.

10. Засгийн газар төрийн өмчит компаниудын хувьчлалыг дэмжих

Төрийн өмчит компаниудыг хувьчлах нь хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээлд оролцох “урилга” болдог. Учир нь энэ нь Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалт татах сонирхолтой байгааг илтгэдэг. Түүгээр ч зогсохгүй зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулдаг билээ. Иймд төрийн өмчит компаниудыг хувьчлах ажлыг яаравчлах хэрэгтэй.

Дүгнэлт


Дээрх 10 арга хэмжээг хэрэгжүүлснээр, миний зүгээс Монголын хөрөнгийн зах зээлийн ирээдүй өөдрөг харагдана гэж үзэж байна. Доорх графикт бүртгэлтэй компаниудын бүтцийн зураглалыг харуулсан болно.

Ойрын хугацаанд дээр дурьдсан 10 арга хэмжээг хэрэгжүүлэх нь зураг өгүүлж буй ирээдүйг Монголын Үнэт цаасны хорооны ирэх 20 жилийн түүхэнд үлдээнэ гэдэгт итгэлтэй байна.

Зорилтот бүртгэлтэй компанийн зураглал

Шинэ хөрөнгө оруулагчид татах түлхүүр үзүүлэлт нь зах зээлд оролцож буй компаниудын чанарыг сайжруулах юм


Зорилтот компаниудын 7 ангилал




ТООН МЭДЭЭ

Үнэт цаасны зах зээлийн сүүлийн жилүүдийн өсөлтийг харуулах голлох тоон үзүүлэлтүүдийг сонирхуулж байна.


1 Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөгөөр)




2 Зах зээлийн үнэлгээний ДНБ-д харьцуулсан харьцаа (хувиар)




3 ТОП-20 индекс




4 Үнэт цаасны зах зээлийн оролцогчид



5 Үнэт цаасны арилжаа




6 Төвлөрсөн хадгаламжид нээгдсэн дансны тоо (өссөн дүнгээр)




7

Ногдол ашиг тараалт




8

Арилжаанд эзлэх хувь (2014.III)




9

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны үнийн дүн (тэрбум төгрөг)



10


Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны мэдээлэл (2014.09.30)



11

ХАА-н биржээр арилжигдсан түүхий эдийн хэмжээ (хувиар)

Ноолуур 21%, Хонины ноос 23%, Тэмээний ноос 4%, Ямааны завод ноос 1%, Ямааны завод ноос*3%, Тэмээний завод ноос0%, Хонины завод ноос 3%, Тосны ургамал45%



12

Хадгаламж зээлийн хоршоодын нийт зээлийн бүтэц



	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Чанаргүй зээл	Нийт зээл
2006	10,4	2,4	0,8	13,6
2007	17,3	0,6	1,4	19,3
2008	29,0	1,2	2,2	32,4
2009	25,6	4,5	2,1	32,2
2010	29,3	2,1	3,5	34,9
2011	38,0	0,9	2,6	41,5
2012	46,0	1,2	1,1	48,3
2013	46,6	1,3	1,5	49,4
2014-III	59,0	1,7	1,7	62,4

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХОРОО БА ХОЛБООДЫН “НӨХӨРЛӨЛ”

Санхүүгийн зохицуулах хороо банкнаас бусад санхүүгийн байгууллагын хяналт зохицуулалтыг хэрэгжүүлэгч байгууллагын хувьд үнэт цаас, бичил санхүү, даатгалын зах зээлийн болон хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн арилжааны хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэгч төрийн байгууллага болно.

Эдгээр зохицуулаттай салбарт үйл ажиллагаа явуулдаг оролцогчид өөрийн үйл ажиллагааны чиглэлээр тус тус холбоотой бөгөөд тэдгээр нь тогтмол үйл ажиллагааг ашгийн бус зорилгоор явуулж байгаа нь санхүүгийн салбарын байгууллагын идэвх санаачилга, нэгдсэн зохион байгуулалтын илрэл юм.

Санхүүгийн салбарын тогтвортой байдалд төрийн зохицуулагч байгууллага, зохицуулалттай зах зээлийн оролцогчдын хамтын ажиллагааны тууштай, нэгдсэн бодлого чухал үүрэгтэй байдаг. Энэ нь төрийн байгууллагын шийдвэр гаргалтад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, улмаар зах зээлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн зохицуулалтыг бий болгодог.

Энэхүү зарчмын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо өөрийн зохицуулалт бүхий зах зээлд үйл ажиллагаа явуулдаг этгээдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйл ажиллагааг нь дэмжих бодлогыг тэдгээрийн төлөөлөл бүхий мэргэжлийн холбоогоор дамжуулан хэрэгжүүлдэг.

Санхүүгийн зохицуулах хороо нь Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо /МҮЦАЭХ/, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо /МББСБХ/,



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа

Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбоо /МХЗХҮХ/-той хоёр талт, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоо болон Биржийн зохицуулах зөвлөлийн ажлын албатай гурван талт Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан хамтран ажилладаг.

Санамж бичгийн үндсэн зорилго нь Хорооны зүгээс зах зээлийн оролцогчидтой хамтран ажиллах механизмыг тодорхойлох, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, зах зээлийн оролцогчдын төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг бодитоор хангах явдал юм. Төрийн зарим эрх, үүргийг тодорхой үе шаттайгаар төрийн бус байгууллагад шилжүүлэх, салбарын эрх зүйн зохицуулалтыг бий болгох, харилцан мэдээлэл солилцож, нэгдмэл сонирхолтой хамтын ажиллагаа, уялдаа холбоог нэмэгдүүлэх асуудлыг мөн санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлдэг.

Мөн түүнчлэн зах зээлийг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх зорилгоор салбарын бодлогын болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах зэрэг үр нөлөө бүхий зохистой, нягт хамтын ажиллагааг хэвшүүлж байна.

Нөгөөтэйгүүр, салбарын мэргэжлийн холбоодтой санамж бичиг байгуулсанаар манай улсын зах зээл дээр туйлын шаардлагатай байгаа өөрөө өөрийгөө зохицуулах зах зээлийн бүтэц, стандарт бий болох, улмаар илүү үр нөлөө бүхий хяналт зохицуулалтыг төрийн оролцоогүй хэрэгжүүлэх орчин цаашид үүсэх томоохон түлхэц болж байгаа юм.

Төрийн зохицуулагч байгууллага нь өөрийн зохицуулалтын салбарын чиг

хандлага, стратегийг боловсруулах чиг үүрэгтэй бодлогын зөвлөлийн тогтолцоог бий болгон дэргэдээ ажиллуулдаг олон улсын жишиг бий.

Үүний нэгэн адил зах зээлийн хөгжил, бодлого, зохицуулалтын болон бусад шаардлагатай асуудлыг хэлэлцэх, тухайн асуудлаар санал, зөвлөмж боловсруулах үндсэн чиг үүрэгтэй “ББСБ-ын орон тооны бус бодлогын зөвлөл”, “ХЗХ-ны орон тооны бус бодлогын зөвлөл”, “Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөл”, “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжааны орчны бодлогын зөвлөл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо дэргэдээ байгуулан хамтран ажиллаж байна. Уг Бодлогын зөвлөлийн гишүүд нь зах зээлийн оролцогчид, холбогдох мэргэжлийн холбоод, их, дээд сургуулийн эрдэмтэн, судлаачид, Сангийн яам, Монголбанк, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Төрийн өмчийн хорооны төлөөллөөс тус тус бүрддэг.

Бодлогын зөвлөл тус бүр өөрийн үйл ажиллагааны дүрэмтэй бөгөөд тогтмол хугацаанд болон зах зээлийн цаг үеийн тулгамдсан асуудлаар тухай бүр хуралдаж холбогдох санал, зөвлөмжийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх, улмаар Хорооноос тэрхүү санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх, эрх бүхий зохих байгууллагад уламжлах, тэдгээртэй хамтран ажиллах зарчмыг хэвшүүлэн ажиллаж байна.

Төрийн байгууллага төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаач, зах зээлийн мэргэжлийн оролцогчидтой тулгамдаж буй асуудлаар зөвлөлдөх, хэлэлцэх нь тухайн асуудлыг шийдвэрлэх гарц, гаргалгааг онол, практикийн үүднээс харж, боломжит хамгийн зөв шийдвэрт хүрэх бололцоог олгодог. Улмаар цаашдын чиг хандлагыг тодорхойлох, аливаа дүрэм, журам боловсруулахад санал солилцох зарчмыг сүүлийн жилүүдэд баримтлан ажиллаж байна.

Ийнхүү мэргэжлийн оролцогчдыг үйл ажиллагаандаа оролцуулах, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, нөгөөтэйгүүр, хувийн хэвшлийг төрийн зүгээс бодлогын хүрээнд дэмжин ажиллах нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны бат бэх суурь болох юм.

Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний хувьд Монголбанк, Сангийн яамтай тогтмол хуваарийн дагуу болон цаг үеийн асуудлаар тухай бүр хуралдах, санал солилцох, Үндэсний статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Архивын ерөнхий газар болон бусад байгууллагатай мэдээлэл солилцон ажилладаг. Түүнчлэн зах зээлийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээг боловсруулах чиглэлээр МУИС-ийн Бизнесийн удирдлагын сургуулийн багтай хамтран судалгаа хийх, СЭЗДС, ШУТИС-ийн КТМС, “Мандах бүртгэл” дээд сургуулийн төгсөх курс болон магистрын оюутнуудад мэдээлэл өгөх, лекц унших зэрэг ажлыг зохион байгуулж цаашид тогтмолжуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Зохицуулалттай зах зээлийн оролцогчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, өөрийн ажилчдыг мэргэшүүлэх үүднээс Компанийн засаглалын үндэсний төв, ММНБИ, Банк санхүүгийн академи зэрэг байгууллагатай хамтран ажилладаг. ■

ХАМТЫН АЖИЛЛАГАА

ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ХАРИЛЦАА

Өнгөрөгч 20 жилийн хугацаанд Монгол Улсын санхүүгийн зах зээл үлэмж хэмжээнд хөгжиж дэвшлээ. Монгол Улсын эдийн засаг интеграцчилагдахын хэрээр санхүүгийн зах зээл хил дамнан тэлж, олон улсын түвшинд хөгжих шаардлага зүй ёсоор тавигдаж ирсэн билээ. Үүний сацуу манай эдийн засагт уул уурхайн салбар голлох үүрэг гүйцэтгэж, эдийн засаг хоёр оронтой тоогоор өсч эхэлснээр гадаадын хөрөнгийн бирж дээр үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах, давхар бүртгэх зэрэг шинэ зохицуулалтыг бий болгох, үнэт цаас, бичил санхүү, даатгал зэрэг салбаруудын хууль эрх зүйн орчныг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх гэх зэрэг олон асуудал хөндөгдөж ирснийг олон улсын болон түншлэгч байгууллагуудын хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр шат дараатай арга хэмжээ авч, бодит ажил болгон хэрэгжүүлж чадлаа.

Өнөөдөр Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн орчин, зохицуулалтын механизм нь олон улсын хэм хэмжээнд хүрсэн байгаа бөгөөд үүнийг илэрхийлэх хэмжүүр бол Санхүүгийн Зохицуулах Хороо нь Үнэт Цаасны Хороодын Олон Улсын Байгууллага /International Organization of Securities Commission /IOSCO//-ын Олон талт харилцан ойлголцлын санамж бичигт 2014 оны зургаадугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсон явдал яах аргагүй мөн юм.

Дээрх санамж бичигт нэгдэн орсноор тус санамж бичгийн гишүүн болох 180 гаруй орны үнэт цаасны зохицуулалтын байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломж нээгдэж байна. ▸▸



Үнэт Цаасны Хороодын Олон Улсын Байгууллага /International Organization of Securities Commission /IOSCO//-ын Олон талт харилцан ойлголцлын санамж бичиг 2014 оны зургаадугаар сарын 18-ны өдөр гарын үсэг зурав.

Хороо нь банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хөгжлийг богино хугацаанд олон улсын жишигт хүргэн хөгжүүлэх, зохицуулалтыг боловсронгуй болгох, албан хаагчдын чадавхийг сайжруулах чиглэлээр Япон улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Польш улс, Бүгд Найрамдах Казахстан улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Хонконг /ЗЗОБ/ зэрэг орнуудын санхүүгийн зохицуулагч байгууллагуудтай Хамтран ажиллах, мэдээлэл солилцох тухай хоёр талт Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулаад байна. Энэхүү санамж бичгүүдийн хүрээнд манай зохицуулалтын хүрээний салбаруудын хууль эрх зүйн орчныг сайжруулах, хөгжлийг эрчимжүүлэх, Хорооны болон салбарын чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн санхүүгийн мэдлэгийн сайжруулах зэрэг чиглэлээр олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн, хамтран ажиллаж байна.

Тухайлбал, Люксембургийн Их Вант Улсын Засгийн Газар, Люксембургийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр “Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх болон сургалтын төсөл”, Япон Улсын Санхүүгийн үйлчилгээний агентлагтай хамтран “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхийг сайжруулах төсөл”, Дэлхийн банкны санхүүжилтээр “Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн чадавхийг бэхжүүлэх тухай төсөл”, ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран “Бичил даатгалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох”, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй, Япон Улсын Ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр “Эмзэг бүлгийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл” гэх мэт төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байгаа болно.

2008 онд байгуулагдсан хэдий ч бичил санхүүгийн салбарт хүч түрэн орж ирсэн нэг байгууллага бол Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /Alliance for Financial Inclusion /AFI// бөгөөд СЗХ нь гишүүн байгууллагаар 2010 оны зургаадугаар сард элсэн орсон байдаг. Тус байгууллагын дэмжлэгтэйгээр Монгол Улсад цахим мөнгөн гүйлгээ болон гар утсаар төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээг нэвтрүүлэх хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгож, санхүүгийн үйлчилгээг иргэдэд илүү хүртээмжтэй болгоход хувь нэмрээ оруулсан билээ. Цаашид малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор малчдыг Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаанд үүсмэл санхүүгийн хэрэгслийг ашиглан шууд оролцуулах боломжийг бий болгохоор хамтран ажиллаж байна.

Улаанбаатар хотын бүс нутгийн санхүүгийн төв болгон хөгжүүлэх зорилтын хүрээнд өнгөрөгч есдүгээр сард Азийн хөгжлийн банк, Ази-Номхон далайн орнуудын Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагатай хамтарсан олон улсын сургалтыг “Хөрөнгө оруулалтын сангийн хяналт ба зохицуулалт” сэдвээр анх удаа Монгол Улсад зохион байгууллаа. Энэхүү сургалт нь Ази-Номхон далайн бүсийн нийт 12 орны 60 гаруй төлөөлөгч, санхүүгийн зах зээлийн оролцогчдыг хамруулсан бүс нутгийн томоохон арга хэмжээ болсон бөгөөд АНУ, Австрали Улсын санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагын олон жилийн туршлагатай мэргэжилтнүүд удирдан явуулав.

Хороо нь цаашид Монгол Улсын санхүүгийн зах зээлийг олон талтгуурт болгон хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэ технологи нэвтрүүлэх, нутагшуулах болон санхүүгийн зах зээлийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн хөгжүүлэх, санхүүгийн зах зээлийн нэгдсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх, эрх зүйн орчинг зах зээлийн хөгжлийн загварт нийцүүлэн шинэчлэх чиглэлээр олон улсын болон түншлэгч байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлтэй байна.

Энэ дашрамд Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хөгжилд хувь нэмрээ оруулсан, бидний үйл ажиллагааг байнга дэмжин ажилладаг олон улсын байгууллага, Засгийн газар, зохицуулагч байгууллагуудад чин сэтгэлийн талархал илэрхийлье. ■

TDB

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



МОБАЙЛ ПОС МОНГОЛД

Борлуулалтаа өсгөх шилдэг арга

Утас: 1900-1977 | Мессэж: 133133 | И-мэйл: info@tdbm.mn | Вэб хаяг: www.tdbm.mn | Facebook: www.tdbm.mn/facebook
Twitter: www.tdbm.mn/twitter | Viber: +976 99001977 | Skype: tdb_info | Yahoo: info_tdb@yahoo.com

ТӨСӨЛ

НАСАНД ХҮРЭГЧДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД

А.БҮРЭНЖАРГАЛ

Санхүүгийн боловсролын мессэж агуулсан киноны дүрүүдийн амжилт болон сургамжаас суралцсанаар иргэдийн санхүүгийн мэдлэг сайжрах боломжтой аж.

Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлж байгаа “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг сайжруулах чиглэлээр Монгол Улсад анх удаа санхүүгийн боловсролын “Фокус” группын судалгааг хийсэн байна. Тус судалгааг Дэлхийн банкны “Санхүүгийн чадамж ба хэрэглэгчийн хамгаалал” судалгааны үр дүнтэй харьцуулж, насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэхэд туслах энэ чиглэлийн мессэжүүд болон тэдгээрийг олон нийтэд хүргэх мэдээлэлийн суваг ба хэлбэрүүдийг агуулсан “Санхүүгийн Боловсролын Маркетингийн Төлөвлөгөө”-г боловсруулжээ.

Уг судалгааны үр дүнд иргэдэд санхүүгийн боловсрол олгох хамгийн хүртээмжтэй суваг нь телевиз бөгөөд хэлбэрийн хувьд олон ангит кино нь хамгийн их мессэж мэдээллийг агуулдаг учраас эдгээрийг нэгтгэн телевизийн олон ангит уран сайхны киногоор дамжуулан санхүүгийн боловсролын мессэжийг түгээх шийдлийг сонгосон байна.

Учир нь киноны гол дүрийн баатруудын амьдралд тохиолдож байгаа санхүүгийн ололт амжилт, саад бэрхшээл түүнийг шийдвэрлэж байгаа арга барилыг бодит амьдралд тулгуурласан санхүү мөнгөний харилцаагаар дамжуулан адармаатай үйл явдлаар баяжуулж олон нийтийн хүртээл болгосноор иргэд дүрүүдийн амжилт болон сургамжаас суралцах боломжтой аж.

Улаанбаатар хот болон орон нутгийн иргэдийн 213 төлөөлөлд туршилтын хоёр ангит киног үзүүлж үнэлгээ хийлгэсний үр дүнд олон ангит уран сайхны киног бүтээх ажил хийгдэж



Санхүүгийн зохицуулах хорооноос насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг сайжруулах зорилгоор телевизийн олон ангит кино хийж байна.

байна гэж төслийн зохицуулагч хэлж байна. Энэхүү “Саятан болгох дамжаа” телевизийн олон ангит киног ирэх оны нэгдүгээр сард орон даяар цацалттай телевизийн сувгаар дамжуулан олон нийтийн хүртээл болгож үр дүнг санал асуулга болон үүрэн утасны мессэжээр дамжуулан үнэлэх юм байна.

Зорилтот бүлгийнхний санхүүгийн үйлчилгээ хамгийн түгээмэл авдаг ХЗХ-дыг чадавхжуулах, зохицуулалтын орчинг сайжруулах нь төслийн үйл ажиллагааны нэг бүрэлдэхүүн хэсэг юм.

“Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” төсөл хэрэгжих болсон үндэслэл нь ХЗХ-ны талаарх иргэдийн мэдлэг ойлголт бага, ХЗХ-ны зохицуулалтын орчин тааруу, салбарын боловсон хүчний чадавхи сул түүнчлэн иргэдийн санхүүгийн үйлчилгээний талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй, хуримтлал байхгүй, мэдээлэл дутмаг байгаа зэрэг нь ядууралд амархан өртөх шалтгаан болж байгааг судалгаагаар тогтоожээ. Үндэсний хэмжээнд нийт өрхийн зөвхөн 31 хувь, ядуу өрхийн 13 хувь нь албан ёсны санхүүгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа нь хангалтгүй гэж үзжээ.

Төслийг Азийн Хөгжлийн банкаар дамжуулан ядуурлыг бууруулах Японы сангаас 2.5 сая ам.долларааар санхүүжүүлж байгаа аж.

Төсөл нь хүлээгдэж байгаа үр дүн, үр нөлөөг бий болгохын тулд



> Төслийг Азийн Хөгжлийн банкаар дамжуулан ядуурлыг бууруулах Японы сангаас 2.5 сая ам.долларааар санхүүжүүлж байгаа аж.

зорилтот бүлгийнхний санхүүгийн үйлчилгээ хамгийн түгээмэл авдаг тэдэнд хамгийн ойр санхүүгийн институт нь Хадгаламж, зээлийн хоршоод учраас (ХЗХ)-дыг чадавхижуулах, зохицуулалтын орчинг боловсронгуй болгох иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах замаар Монгол улсын ядуу болон эмзэг бүлгийн иргэдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэжээ. Тодруулбал, өнгөрсөн хугацаанд ХЗХ-дын зохицуулалтын орчин, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналт шалгалтын талаар таван бүсийн 136 ХЗХ-дын 348 удирдах ажилтнуудыг хамруулж сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулжээ. Хэлэлцүүлгийн үр дүнд оролцогчдын санал зөвлөмжийг нэгтгэн зохицуулалтын журмыг өөрчлөн сайжруулах үйл ажиллагаа хийжээ.

Ингэснээр нийт ХЗХ-дын 90 гаруй хувь нь хууль журамд нийцсэн үйл ажиллагаа явуулж байна гэдгийг төслийн багийнхан онцолсон.

ХЗХ-дын 93 хувийг хамруулсан чадавхийн суурь үнэлгээгээр хоршоодод шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлон гаргаж, төслийн олон улсын болон үндэсний зөвлөх, салбарын мэргэжилтнүүдтэй хамтарч “ХЗХ-ны зарчим, сайн туршлага”, “ХЗХ-ны засаглал ба гишүүдийн оролцоо” сэдвээр цаашид ашиглагдах 2 төрлийн иж бүрэн шинэ сургалтын модуль боловсруулсан.

Эдгээр сэдвээр ХЗХ-дод сургалт явуулах салбарын сургагч багш нарыг мөн л салбарт ажиллаж буй удирдлага, ажилтнуудаас бэлтгэсэн. Монголын хадгаламж зээлийн хоршоодын холбоо (МХЗХХ), Монголын Хоршооллын сургалт мэдээллийн төвд (МХСМТ) төслөөс 60-аад сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмжөөр хангаж хоршооллын байгууллагуудыг сургалтын материллаг бааз, боловсон хүчин, сургалтын арга зүйн хувьд чадавхжуулсанаар цаашид салбарын байгууллагууд бие даан сургалт явуулах орчин бүрдсэн.

Ингэснээр 2013 онд ХЗХ-дыг чадавхжуулах сургалтыг интернэт болон танхимын аргаар нийт 39 сургалт зохион байгуулж 134 ХЗХ-ны 973 гүйцэтгэх удирдлага, сонгуультнууд хамрагдсанаар ажилтнуудын мэдлэг сайжирч ажлын бүтээмж дээшилсэн.

Цаашид төслийн хүлээгдэж буй үр дүнд ХЗХ байршдаг газар нутгийн хүн амын 50 хувь нь санхүүгийн суурь ойлголттой болж, санхүүгийн үйлчилгээнд хамрагдсан байна гэж үзэж буй аж. Түүнчлэн “Саятан болгох дамжаа” телевизийн олон ангит киног нийт хүн амын 30 хувь үзсэн байхаар тооцоолсон байна.

Төслийн явцад Азийн хөгжлийн банкны зүгээс хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд энэ оны зургадугаар сарын байдлаар төслийн хэрэгжилтийг 75 хувьтай гэж үзжээ.

Уг төсөл нь 2012 онд эхэлсэн бөгөөд 2016 он хүртэл үргэлжилнэ. ■

ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС



1994

"Улсыг аюулаас хамгаалах газар" нэртэйгээр анхны даатгалын байгууллага үүсэн байгуулагдав.

1990

Анхны даатгалын компани байгуулагдав

1991 01 сар 18

Засгийн газрын 22 тоот тогтоолын дагуу Монголын Хөрөнгийн биржийг байгуулагдав

1992 02 сар 07

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа эхлэв

1994

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай анхны даатгалын компани байгуулагдав

Сангийн сайдын тушаалаар даатгалын компаниудад зөвшөөрөл олгохтой холбоотой журмыг батлав

1994 09 сар 26

Үнэт цаасны тухай анхны хууль батлагдав

1994 11 сар 14

Үнэт цаасны хороо байгуулагдав



2003 10 сар

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болох "ҮЦТТТХТ" ХХК байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж эхлэв

Үнэт цаасны хороодын Олон улсын байгууллага /IOSCO/-ын гишүүн болов.

2002

Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан 6 дугаар бүлгийг нэмж, хоршоодын хадгаламж, зээлийн үйл ажиллагааны талаар нарийвчлан зохицуулав.

2004

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоонд мөрдөх зохистой үзүүлэлт, эрсдэлийн сангийн доод хэмжээг тодорхойлох журмыг Төв банкнаас тогтоож, хяналт тавихаар хуульчиллаа.

Монголын Банк Бүс Санхүүгийн Байгууллагуудын Холбоо /МББСБХ/ байгуулагдав.

2004 04 сар 30

Даатгалын тухай хууль шинэчлэн батлагдав.

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль батлагдав.

2005

Бичил санхүүгийн байгууллагуудын хөгжлийн зөвлөл байгуулагдав.

2005 01 сар 19

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг баталж, Хоршооны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулж, Санхүүгийн зохицуулах хороонооос хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгохоор хуульчиллаа.

2005 01 сар 19

Монголын даатгагчдын холбоо байгуулагдав.

2005 11 сар 17

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль батлагдав.



2006

Хадгаламж, зээлийн хоршооны хямрал явагдсан

2006 01 сар 25

Банкнаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах чиг үүрэг бүхий Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдав.

2007

"Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн жил" болгон зарлав. Хоршооны тухай хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталж, уг хуулийн хүрээнд 420 хоршоо татан буугдсан.

Хохирлыг эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах журмын дагуу ХЗХ-дын гишүүдийн хохирлын 50 хувь болох 36,1 тэрбум төгрөгийг төрөөс олгов.

2007 06 сар 28

Хоршооны тухай хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдав.

2007 06 сар 29

Монголын Хадгаламж Зээлийн Хоршоодын Үндэсний Холбоо /МХЗХУХ/ байгуулагдав.

2007 08 сар 203

Хохирлыг эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах тухай хууль батлагдав.



2011 04 сар 09\7

Монголын хөрөнгийн бирж Лондонгийн хөрөнгийн биржтэй "Ажлын мастер гэрээ"-нд гарын үсэг зурлаа.

2011 03 сар 09

"Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" батлагдав.

2011 10 сар 06

Компанийн тухай хууль шинэчлэн батлагдав.

2011 10 сар 06

Албан журмын даатгалын анхны хууль болох Жолооочийн даатгалын тухай хууль батлагдав.

2011 10 сар 27

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль батлагдав.

2011 11 сар

Албан журмын даатгагчдын холбоо байгуулагдав.

2012 04 сар 27

"Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги (2012-2016)"-г батлав.



2012 07 сар 02

Монголын хөрөнгийн зах зээлд "Эм Ай Ти" шинэ систем нэвтэрснээр үнэт цаасны төлбөр тооцоо Т+3 системд шилжлээ.

2012 10 сар

Монголын даатгалын зуучлагчдын холбоо байгуулагдав.

2012

Төлбөр тооцооны үйл ажиллагааг арилжааны 4 банкаар гүйцэтгэдэг болов.

2012

МХЗХХ, МХСМТ-тэй хамтран АХБ-ны шугамаар Япон улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламжаар "Ядуу иргэдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийг хэрэгжүүлж эхлэв.

2013 03 сар 13

Хөдөө аж ахуйн бирж дээр арилжааны зуучлагч/брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх анхны тусгай зөвшөөрөл олголоо.

2013 05 сар 24

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль шинэчлэн батлагдав.

1995

Хоршооны тухай хууль батлагдав

1995 07 сар 31

Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо байгуулагдав.

1995 08 сар 27

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь дансанд анхны мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийгдлээ.

1995 08 сар 28

-Монголын хөрөнгийн биржийн анхны арилжааны төлбөр тооцоог урьдчилан мөнгө байршуулах зарчмаар Т+0 хугацаанд хийж гүйцэтгэв.

-"ТОП-75" индекс тооцож эхлэв.

-Үнэт цаасыг бэлэн мөнгөөр арилжих буюу үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэв.

1996

Банкны тухай хуулийн 2.6-д заасны дагуу Хоршоодод хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Монголбанк олгох болов.

1996 10 сар 25

Засгийн газрын бондын анхны арилжаа явагдлаа.

1996 11 сар 19

Анхны хадгаламж, зээлийн хоршоог "Монкорд" нэртэйгээр үүсгэн байгууллаа.

1997 12 сар 05

Даатгалын тухай хууль батлагдав.

1998

Хоршооны тухай хууль шинэчлэгдэн батлагдав.



1998 03 сар 25

Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу Даатгалын хяналтын алба байгуулагдав.

1999

Анхны банк бус санхүүгийн байгуулагдав.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хадгаламж, зээлийн хоршоо Монголбанкинд хамааралгүй болов.

1999 07 сар 02

Компанийн тухай бие даасан анхны хууль батлагдав.

1999 11 сар 01

Нэгдсэн индекс тооцож эхлэв.

2000 01 сар 21

Гадаадын хөрөнгө оруулалттай анхны брокер, дилерийн компани бий болов.

2001 06 сар 08

Компанийн бондын арилжаа явагдаж эхлэв.

2002 10 сар

Сангийн яам нь Олон улсын даатгалын хяналт шалгалтын байгуулагаа /IAIS/-ын гишүүн болов.



2002 12 сар 12

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль шинэчлэн батлагдав

2002 12 сар 12

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль батлагдав.



2007 12 сар

Валют солих цэгүүдийн үйл ажиллагаа нь Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтын хүрээнд хамрагдахаар болов.

2007 12 сар 26

Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Хөгжлийн байгууллагаас батлагдсан "Компанийн засаглалын зарчмууд"-д үндэслэн үндэсний "Компанийн засаглалын кодекс"-ийг батлав.

2008

Урт хугацааны даатгалын анхны компани байгуулагдав.

2008 03 сар 05

"Блүүмбэрг" агентлагтай үнэт цаасны зах зээлийн мэдээллийг дамжуулах гэрээ байгуулав.

2008 04 сар 10

Монголын хөрөнгийн бирж Ази номхон далайн орнуудын хөрөнгийн биржүүдийн холбоонд гишүүнээр элсэв.

2009

-Үнэт цаасны хороодын олон улсын байгуулагаа (IOSCO)-ын "Олон талт харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн "Б" хавсралтад нэгдэн орлоо.

-Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаанд ашиглагдах иж бүрэн "E-Clearing house" системийг ашиглатанд оруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүллээ.

-Онлайн дансны үйлчилгээг нэвтрүүллээ.

2009 07 сар 09

-Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль батлагдав.

2009 07 сар 09

-Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулав.

2009 07 сар 09

Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй банкнаас бусад хуулийн этгээд, иргэдийн гүйцэтгэж буй төлбөр тооцооны хяналтын асуудал Хорооны зохицуулалтын үйлчилгээний хүрээнд хамаарагдахаар хуульчлагдсан.

2010

Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоотой харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

2010 04 сар 23

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг батлав.

2010 08 сар 31

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ анх удаа нэг их наяд төгрөгөөс давлаа.

2010 10 сар 11

Төвлөрсөн хадгаламж дахь үнэт цаасны бүртгэлийг ISO6166 олон улсын стандартын дагуу бүртгэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангаж, олон улсын стандартыг хэрэгжүүлэгч байгуулга болох ANNA-д хамтрагч байгуулагаар элсэн орлоо.



2013 10 сар 11

Хонконгийн Үнэт цаас, фьючерсийн хороотой мэдээлэл солилцох, харилцан хамтран ажиллах санамж бичиг байгуулаа.

2013 10 сар 03

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль шинээр батлагдав.

2013 06 сар 17

"Даатгалын хохирол үнэлэгчдийн холбоо" ГҮ ТББ байгуулагдлаа.

2014

Хадгаламж, зээлийн хоршоодын анхдугаар форум зохион байгуулагдлаа.

2014 06 сар 13

Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль батлагдав.

2014 06 сар 18

Үнэт цаасны хороодын олон улсын байгуулагаа /IOSCO/-ын олон талт санамж бичигт нэгдэн орлоо.

ДУРСАМЖ

АМЬДРАЛЫН ИХ СУРГУУЛЬД АЖИЛЛАСНАА ЭРГЭН САНАХАД САЙХАН БАЙНА



ЖИГЖИДСҮРЭНГИЙН ЯДАМСҮРЭН

Үнэт цаасны хорооны анхны дарга асан, Төрийн захиргааны албаны тэргүүн түшмэлийн Тэргүүн зэрэгтэй, эдийн засгийн ухааны доктор, профессор

Монгол Улсын Их хурлын 1994 оны арваннэгдүгээр сарын 14-ний өдрийн шийдвэрээр Монгол Улсын Үнэт цаасны хороог анх байгуулж, намайг даргаар нь томилсон юм. Хорооны гишүүдээр Д.Буянтогтох, Д.Энхжаргал, Б.Гантөмөр, Д.Балдан-Очир нарыг томилж байлаа. Үнэт цаасны хороог байгуулсан нь зах зээлийн эдийн засагт шилжиж буй Монгол Улсын хувьд нэгэн чухал үйл явдал болсон юм. Зах зээлийн эдийн засагтай орны санхүүгийн салбарын зайлшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг болох үнэт цаасны зах зээл “ажиллаж” эхлэхэд түүнийг зохицуулах, хянах байгууллагыг үүсгэн байгуулсан хэрэг байлаа.

Хоосон газар, цоо шинэ ажилд бид томилогдох нь тэр. Байгууллага нь ч шинэ, ажил нь ч шинэ, хүмүүс нь ч шинэ. Нийгмийн өмч ноёрхсон өмнөх 70 жилд үнэт цаасны зах зээл Монгол Улсад ерөөс байгаагүй, байх ч учиргүй мэт байлаа. Эл зах зээл өмч хувьчлах явцад шинээр үүссэнээрээ онцлог байв. Ингэж бидний өмнө өвөрмөц маягийн үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хянах эрх бүхий төрийн байгууллагыг үүсгэн байгуулж, чиг үүргийг нь хэрэгжүүлэн ажиллах үүрэг ногдсон юм.

Юуны өмнө мэргэжлийн сайн аппарат бүрдүүлэх, түүнийгээ чадварлаг боловсон хүчнээр хангах, тэднийг сургах шаардлага гарсан. Америкаас эрдэмтэн, практик ажилтан, багш нарыг урьж хороонд 45 хоногийн сургалт, семинарыг хоёр үе шаттайгаар анх явуулж билээ. Уг ажлыг 1995 оны эхний хагаст дуусгав. Миний бие АНУ-ын Үнэт цаасны зах зээлийн институтэд хоёр сарын хугацаагаар явж суралцан удалгүй Вена хотод ОУВС-гийн институтийн сургалтад хамрагдсан юм.

Ийнхүү Үнэт цаасны хорооны ажиллах чиг үүргийн дагуу хорооны аппаратаа зохион байгуулав. Хөрөнгө оруулалт, бүртгэлийн чиглэлээр Бүртгэл санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, зах зээлийг зохицуулах чиг үүргээр Зах зээлийн зохицуулалтын хэлтэс, хуулийг хэрэгжүүлж, хяналт тавих чиглэлээр Хяналт шалгалтын хэлтэс, албан багууллагын чиг үүргийн дагуу Дотоод ажлын тасаг гэх үндсэн дөрвөн нэгжтэй байгуулж ажлын гараагаа эхлүүлэв. Энэ зохион байгуулалт цомхон хэдий ч зөв байсан нь бидний ажилын үр дүнгээр илэрсэн билээ.

Юуны өмнө нөхдийнхөө хүчин чармайлтаар үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хянах эрх зүйн үндсийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж, 30 гаруй заавар, журам, дүрэм боловсруулж мөрдүүлсэн. Эдгээр баримт бичгийг Монгол Улсад анх удаа хэрэгжүүлж, үнэт цаасны зах зээлийн харилцааг зохицуулснаараа түүхэнд үлдсэн билээ. Бүрэн эхээрээ “Үнэт цаасны зах зээлийг зохицуулах хууль, эрх зүйн бусад акт” хэмээх 1995-2000 оны хооронд хэвлэгдсэн 12 эмхтгэлд бий. Энэ бүхний үндсэн дээр 475 »

хувьцааг компанийн хувьцааг бүртгэж, зах зээлд ажиллах байгууллагуудад зөвшөөрөл олгож, тэнд ажиллах хүмүүсийг бэлтгэн аттестатчилж, үнэт цаасны хоёрдогч зах зээлийг эхлүүлэх бэлтгэлийг хангасан юм.

Үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, УИХ-д хүргүүлж, 2002 онд батлуулж билээ. Энэ нь зайлшгүй зүйл байлаа. Үнэт цаасны тухай хууль урьд нь хоосон газар боловсруулан баталсан хууль байсан юм. Практикт үүссэн зайлшгүй зохицуулах олон асуудлыг хуульчлах шаардлага гарсан. Манайд үнэт цаасны зах зээл анхнаасаа цэгцтэй, зохион байгуулалт сайтай хөгжсөн юм. Энэ бол гаднынхны туршлага, тусламж дэмжлэг, хамтран ажилласан нөхдийн минь хөдөлмөрийн үр дүн билээ. Монгол Улсад үүссэн үнэт цаасны зах зээлийн онцлогийг харгалзан, бодлого зорилтоо жил жилийн төрийн мөнгөний бодлогод тусган ажиллаж эхэлсэн. Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх хөтөлбөр, үзэл баримтлалыг ч бид боловсруулан мөрдөж байлаа.

Манайд дутагдаж, бэрхшээл учруулж буй зүйл нь зах зээлийн талаарх хүмүүсийн мэдлэг дутмаг явдал. Шинэ зах зээлийг хөгжүүлэхэд хүмүүсийн мэдлэгийг дээшлүүлэх нь тулгамдсан асуудал байв. Үүнийг анхааралдаа авахаас өөр аргагүй болсон. Ахмад дипломатч Б.Дашцэрэн гуайтай хамтран “Үнэт цаасны зах зээлийн нэр томъёоны толь, товч тайлбар” ном гаргасан юм. Бусдын туршлагаас суралцах, дэлгэрүүлэхийг оролдож, “Үнэт цаасны хөгжингүй зах зээл: үүсэл, хөгжил, дэд бүтэц, хандлага, туршлага” номоо ч мөн гаргав.Номны маань гол санаа нь хугацаа хожиж хөгжих тухай, бусад орны туулсан бэрхшээлтэй бүх замыг давтахгүйгээр өнөө үеийн хөгжлийг урдаас тосон хөгжиж болох тухай гаргаж тавьсан юм.

Бид тухайн үедээ 400 гаруй жилийн түүхтэй зах зээлийг 10 хүрэхгүй жилийн Монголынхтой харьцуулж өндөр үр дүн хүлээсэн байж магадгүй. Нөгөө талаар улс орны эдийн засгийн тухайн үеийн ерөнхий байдал, хуримтлалын хомсдол эл зах зээлийн хөгжилд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байсныг хэлэх нь зүйтэй.

Үнэт цаасны хоёрдогч зах зээл, биржийн арилжааг 1995 оны наймдугаар сарын 28-нд эхлүүлсэн. Тэр үеийн голлох сонинд биржийн арилжааны мэдээ дэлгэрэнгүй байдлаар өдөр бүр хэвлэгддэг байлаа. Хувьцааг цөөхөн эздэд төвлөрүүлэх бодлогыг хэрэгжүүлсэн.

Миний бичсэн “Монгол Улсын үнэт цаасны зах зээл” номд үнэт цаасны хоёрдогч зах зээлийг эхлүүлэхийн тулд манай хорооныхны хийсэн бүх ажил хураангүй орж үлдсэн билээ.

Тэр үед Үнэт цаасны хороог хөрөнгө мөнгө их мэддэг газар гэж хүмүүс ойлгодог байв. Зарга маргаан тасардаггүй байсан нь бидний ажилд ихээхэн хүндрэл учруулдаг байсан даа. Өмч хөрөнгөө булаацалдсан этгээд ирж хороогоор заргаа шүүлгэнэ. Үнэт цаасны зах зээлд гарах маргаан зөрчлийг шийдвэрлэнэ. Хүний өмч, хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцна. Хэцүү ажил даа.

Бидэнд тавигдах ганц шаардлага бол хуулийн дагуу шударга ажиллах, аль нэг этгээдийг хохироохгүй, эрх ашгийг нь хамгаалах явдал байсан. Албаны нөхөддөө ч энэ тухайд хатуу сануулж хэлдэг байсан. Хөнгөдөж болохгүй алба байсан. Манай нөхөд ч намайг, миний байр суурийг сайн ойлгодог байлаа. Тэнд хамт ажилласан олон сайн нөхдөө, бэлтгэгдсэн олон боловсон хүчнээ би ямагт дурсан санаж байдаг юм. Намайг үнэт цаасны зах зээлд ажиллахад хамтран ажилласан бүх хүнд гүнээ хүндэтгэлтэйгээр талархаж явдгаа энэ дашрамд хэлмээр байна. Тэд бүх ажлыг нугалж байлаа. Албаны дарга Ж.Жадамбаа, доктор Д.Сэржамц, Хэлтсийн даргаар ажиллаж байсан доктор Б.Аюуш, Р.Содхүү, Л.Нямдагва, доктор Н.Бүрэн, Д.Сэржамц, О.Энхбаатар, Ө.Цэрэндорж, Х.Володя, мэргэжилтэн Б.Маймөнх, Б.Оюумаа, Н.Батсэлэнгэ, доктор Д.Дуламсүрэн, Т.Бямбасүрэн, Амгалан, Ж.Хэрлэн, С.Цогтбаяр, Б.Одмаа нарын сайн мэргэжилтнүүдээ юуны өмнө дурсах байна. Тэд бол анхдагчид. Тэдний ажил хүнд, ярвигтай ажил. Хүнд ажлыг соргогоор ойлгож, чин үнэнчээр албан үүргээ гүйцэтгэж байсан даа.

Хууль хяналтын байгууллагын хүмүүсийн мэдлэгийг дээшлүүлэх шаардлага ч гарч байсан. Хуульчидтай хамтарч бүх шатны шүүгч, эрүүгийн цагдаагийнхан, прокурор, өмгөөлөгч нарт тусгай семинар, сургалтыг олон удаа зохион байгуулж, гарын авлага бэлтгэж тарааж байлаа. Ажлынхаа зав чөлөөгөөр “Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт” хэмээх 123 хуудастай гарын авлага хүртэл бичиж хэвлүүлж билээ. Ингэхээс ч өөр аргагүй байв. Хуулийнхан хуучин шигээ санаж биржийн болон холбогдох нөхдийг дуудан шалгах нь зарим талаар ажилд хүндрэл учруулдаг байсан.

Хороо 1996-1998 онд зарим их, дээд сургуулийн удирдлагатай хамтран байгуулж, тэр үеийн 475 ХК-ийн бүх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт зах зээлийн болон тэдний хуулиар хүлээсэн үүргийн талаар олон зээлжээр долоо хоногийн хугацаатай тусгай хөтөлбөрөөр сургалт явуулж билээ. Тэдний зах зээл, үнэт цаасны талаарх мэдлэг, хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах шаардлага гарч байсан юм.

Тэр үед зарим удирдах нөхөд өөрт очсон ташаа мэдээлэл эсвэл мэдлэг дутмагийн улмаас дааНч хариуцлагагүй мэдэгдлүүд хийж, үнэт цаасны шинэ зах зээлийг “муулахад” нэлээд хувь нэмэр оруулж байсныг хэлэх хэрэгтэй. Үнэт цаасны зах зээл хүмүүсийн итгэлцэл дээр тогтдог. Бэлтгэгдээгүй улсууд шинэ газар ажиллах нь тохиромжгүй юм билээ. Харамсмаар байсан шүү. Зах зээл ер нь муу биш л дээ. Тэр үед зах зээлийн эдийн засгийн талаарх хүмүүсийн ойлголт хангалтгүй байсанд л хамаг учир оршиж байсан.

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зөв эхлэлийг тавихад урьд надтай хамт ажиллаж байсан манай тэнхимийн багш, шадар сайдаар ажиллаж байсан Д.Ганболд, Хөрөнгийн биржийн анхны захирал Н.Золжаргал нар нэлээд үүрэг гүйцэтгэснийг хэлэх хэрэгтэй. Тэд атар газар хагалж, анхны шан татаж, анхны хүмүүсээ бэлтгэж, Монголын хөрөнгийн бирж гэдэг байгууллагыг анх бий болгож хувьчлалыг явуулсан хүмүүс.

Хорооны гишүүдийнхээ тухайд хэдэн үг хэлье. Д.Буянтогтох мэдлэг чадвар, бэлтгэгдсэн байдлаараа давуу, ноён нуруутай нэгэн. 90-ээд оны эхээр олон улсын байгууллагад ажиллахад Монголоос тэнцсэн. Д.Энхжаргал

гэж гялалзсан шаламгай бүсгүй Монголбанкинд газрын даргаар ажилладаг бас л мэргэжлээрээ чамбай бэлтгэгдсэн хүн. Дараа нь АНУ-д суралцахаар явж билээ. Хувийн сектор төлөөлж АПУ ХК-ийн захирал Т.Гантөмөр аж ахуйн “хатаагдсан”, идэвхтэй боловсон хүчин байлаа. Тэрбээр хорооны хурал бүрт оролцоно, дуугүй сууна гэж үгүй. Хожмын УИХ-ын гишүүн Д.Балдан-Очир бас хувийн сектор төлөөлж байсан. Тэд хороонд сайн ажиллаж, сайхан дурсамж үлдээжээ. Зах зээлийн эдийн засгийн санхүүгийн тогтолцооны нэг чухал тал, улс орны хөгжилд шийдвэрлэх нөлөөтэй, хөрөнгө оруулалтын гол талбар болох үнэт цаасны зах зээл, түүний бүх бүрэлдэхүүн хэсэг зөв голдирлоор цаашид хөгжөөсэй гэж чин сэтгэлээсээ залбирч явдгаа нуух юун.

2000 оны сонгуульд МАХН ялж шинэ Их хурал байгуулагдав. Эдийн засгийн байнгын хорооны даргаар шинэ хүн тавигдаж, Байнгын хорооны хуралдаанаар зургаан жил гаруйн ажлын минь тайланг сонссон. Бас тулгарч байгаа бэрхшээлийн талаар ярилцан хорооны ажилд сайн үнэлгээ өгсөн юм даг. Тэр үеийн хуульд зааснаар хороонд дөрвөн жилийн хугацаагаар биднийг томилсон байсан ч зургаан жил гаруйн хугацаанд ажилласан байлаа. Хуульд заасан хугацаа дууссан тул 2000 оны есдүгээр сарын 1-нд хорооны гишүүдийг шинээр томилж биднийг чөлөөлсөн юм.

Ажилгүй байх хугацаандаа миний бие зүгээр суугаагүй, бэлтгэгдэж мэргэшсэн учраас бичих ажлаа орхиогүй юм. “Үнэт цаас: мөн чанар, үндсэн шинж, чиг үүрэг, төрөл, үнэ, орлого” бүтээлийнхээ үргэлжлэл номоо гүйцээн бичиж, “Үнэт цаасны зах зээл” номоо хэвлүүлж билээ. Үнэт цаасны зах зээлийг сурталчлах, хүмүүст шинэ асуудлаар ойлголт өгөх, сургалтад нэмэр болох зорилго, төлөвлөгөө минь тэгж биелсэн билээ. Миний ажиллаж байх үед ер нь үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд хүмүүсийн мэдлэгийг дээшлүүлэх нь л чухал байсныг өмнө дурьдсан. Одоо ч чухал хэвээр байгаа гэж би боддог юм.

Үнэт цаасны хороонд ажилласан ид насны минь долоо орчим жилийн хугацаа нүд ирмэхийн зуурт өнгөрч, амьдралын их сургуульд ажилласнаа эргэн санахад сайхан байна. Ард түмнийхээ буян заяа, сэтгэл, харамгүй тусалсан гадна, дотны анд нөхдийн хөдөлмөрийн үр шимийг би тэнд хүртэн ажиллаж билээ. Би азтай хүн шүү. Улс эх орондоо цоо шинэ эдийн засгийн харилцааг үүсгэн төлөвшүүлэх үйлсэд үнэнч нөхдийнхээ хамтаар хүч мэдлэгээ зориулсан юм. Энэ дашрамд Монгол Улсын санхүүгийн секторын нэгэн чухал хэсэгт хүч хөдөлмөрөө зориулж бүх талаар тусалж, түшиг болж явсан нөхөддөө Үнэт цаасны зах зээлийг зохицуулагч байгууллага үүссэний 20 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж, сайн сайхан бүхнийг ерөөе. ■

ДУРСАМЖ

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАГЧ ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГТЭЙ



Б.ШАРАВСАМБУУ

Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн асан, Монгол Улсын гавъяат эдийн засагч, Эдийн засгийн ухааны доктор

Зах зээлийн эдийн засгийн хөгжлийн нэг тулгуур нь эрүүл саруул санхүүгийн зах зээл байх учиртай. Нэлээд сайн зүгшэрсэн төсвийн болон банкны системийн зэрэгцээ хөрөнгийн зах зээл, даатгал, бичил санхүүгийн сүлжээг зөв хөгжүүлж зохих байр сууринд нь байлгах явдал тулгамдсан зорилтын нэг юм.

Санхүүгийн зах зээлийн эдгээр шинэ салбарын хөгжилд төр анхаарлаа хандуулж Үнэт цаасны зах зээлийн тухай, Даатгалын тухай, Хоршооны тухай, Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуулийг 90-ээд ▸▸

оны хоёрдугаар хагаст баталж, эрх зүйн орчныг бүрдүүлсэн билээ.

Хөрөнгийн зах зээлийн хяналт, зохицуулалтыг Үнэт цаасны хороо хэрэгжүүлж байсан боловч 90-ээд оны сүүлчээр хөрөнгийн бирж ихээхэн алдагдалд орж, өмч хувьчилалыг биржийн бус арилжаагаар явуулсанаас биржийн “лангуу” хоосорч байсан удаатай. Даатгалын хяналтыг Мэргэжлийн хяналтын газар хариуцаж байсан бөгөөд “Торгон зам” зэрэг даатгалын компани дампуурч бас даатгалын компаниудын нөөц сан дорвитой өсөж чадахгүй байв.

Хоршооны тухай нийтлэг хуулиар хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа зохицуулагдаж, тэдгээрийн хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалт дутагдалтай байснаас 2000-аад оны эхээр Хадгаламж зээлийн ихэнх хоршоодын үйл ажиллагаа доголдож 30 орчим хоршоо дампуурч олон мянган гишүүнийг хадгаламжаар нь хохироож, үүнийгээ улсын төсвөөс нөхүүлсэн гунигт түүх бий.

2005 онд УИХ-аас Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг баталж, улмаар 2006 оны нэгдүгээр сард уг байгууллагыг байгуулсан. Үүнтэй холбогдуулан Үнэт цаасны хороог татан буулгаж, түүний орон тоо, цалингийн фонд болон Монголбанкны Хадгаламж зээлийн хорооны газар, Мэргэжлийн хяналтын газрын Даатгалын хяналтын хэлтсийг тус тус орон тоо, цалингийн хамт Санхүүгийн зохицуулах хороонд төвлөрүүлсэн. Ингэснээр санхүүгийн зах зээлийн төвлөрсөн, хяналт, зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хороо жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх боломж бүрдсэн юм. Үүнээс гадна санхүүгийн зах зээлийн суурь, тулгуур хууль тогтоомжийг сүүлийн 5-6 жилд шинэчлэн гаргасан.

Тухайлбал, 2004 онд УИХ-аас Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг тус тус батлан гаргасан. Эдгээр хууль нь даатгалын компаниудын өсөж дэвжих, үйл ажиллагаа нь өргөжин тэлэх боломжийг нээж, тэдний бие даасан байдлыг баталгаажуулж өгсөний зэрэгцээ Санхүүгийн зохицуулах хорооноос бүрэн эрх, зохицуулалт хяналтын зааг хязгаарыг зөв зүйтэй тогтоосон гэж үздэг. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тухай, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль батлагдан мөрдөж эхэлсэн. Эдгээр хуулийг амьдралд хэрэгжүүлэхийн тулд Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журам, зааврууд тухайлбал, тусгай зөвшөөрлийн нөхцөл болзол, санхүүгийн шалгуур үзүүлэлт зэрэг мэргэжил, арга зүйн удирдамж, төлөвлөгөөт болон гэнэтийн үзлэг шалгалт даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах үйлсэд ихээхэн дэм болж байдаг.

Даатгалын компани болон мэргэжлийн оролцогчдын тоо нэмэгдэж, үйл ажиллагааны хүрээ тэлж, хохирол нөхөн төлөлт өссөөр байгаа нь эрх зүйн орчин сайн бүрдсэнтэй салшгүй холбоотой гэж хэлж болно.

Хадгаламж зээлийн хоршооны тухай бие даасан хууль 2011 онд батлагдан гарсанаар Хадгаламж зээлийн хоршооны хөгжлийн шинэ эрх зүйн орчин бүрдэж чадсан гэж боддог. Хоршооны гишүүдийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгө, хадгаламжийг эрсдэлд оруулахгүй хадгалан өсгөх, зээл олгох, зээлийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд явуулна гэдэг бол үйлдвэрлэл үйлчилгээний бусад хоршооны үйл ажиллагаанаас өвөрмөц, өндөр мэдрэмж, мэргэжил шаардсан ажил. Түүнчлэн хадгаламж, зээлийн хүүг хөдөлгөх гэх мэт цаг хугацаа алдалгүй шуурхай шийдвэрлэвэл зохих олон асуудал Хадгаламж зээлийн хоршооны удирдлагад тулгардаг. Энэ онцлог нь Хадгаламж зээлийн хоршооны хууль бусад хоршооныхоос тусдаа байх зайлшгүй нөхцөл болсон юм. Ийм ч учир тусгайлсан хууль батлагдан гарсан. Ийм төрлийн хоршоод хамтарч холбоо байгуулах, хоршоо тус бүрт байгаа хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг төвлөрүүлж эргэлтэд оруулах, эрсдэлээс хамгаалах дундын сантай байх, мэдээллийн технологийг нэвтрүүлэх зэрэг асуудалд хамтран ажиллах боломжийг энэ хуулиар нээж өгсөн юм.

Санхүүгийн зах зээлийн томоохон тулгуур болох хөрөнгийн зах зээлийн хяналт, зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлдэг. Манай орны хувьд хөрөнгийн зах зээлийн хөгжил төдийлөн өндөр түвшинд хүрээгүй хэдий ч Хорооны хувьд хөрөнгийн зах зээлийн суурь харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг шинэчлэх чиглэлээр шургуу ажиллаж томоохон хуулиудыг шинээр болон шинэчлэн УИХ-аар батлуулсан. Тухайлбал, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг шинэчлэн баталсан бол үнэт цаасны зах зээлд “ус, агаар” мэт хэрэгцээтэй байгаа мэргэжлийн хөрөнгө оруулагчдын харилцааг зохицуулсан Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, үл хөдлөх хөрөнгийн хоёрдогч зах зээлийг хөрөнгөжүүлэх, хөрөнгийн зах зээлтэй холбох, урт хугацааны мөнгөн урсгалыг бий болгох санхүүгийн дэд бүтцийг зохицуулсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиудыг шинээр батлуулах ажлыг гүйцэтгэсэн бөгөөд дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байгаа нь харагддаг.

Цаашид санхүүгийн зах зээлийн дэд бүтэц зөв зохистой хөгжих, олон тулгуур бүхий санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд Монгол улсын санхүүгийн зах зээлийн зохицуулагч байгууллага болох Санхүүгийн зохицуулах хорооны үүрэг, оролцоо, хүчин чармайлт туйлын чухал байх нь дамжиггүй юм.

Ингээд Санхүүгийн зохицуулах хорооныхоо нийт хамт олон, түүний зохицуулалтын салбарын нийт бие бүрэлдэхүүнд ажлын улам их амжилт хүсч, эрүүл энх аз жаргалыг хүсэн ерөөе. ■



Үнэт цаасны хорооны анхны хамт олон АНУ-ын зөвлөх мэргэжилтнүүдийн хамт. 1995 он



Засгийн газрын бондын анхны арилжаа. 1996.10.25




Үнэт цаасны хорооны хамт олон. 2004 он



Үнэт цаасны хорооны хамт олон. 2004 он



Зүүн гар талаас / Хойд эгнээ/ Г.Даваасамбуу СЗХ-ны Тамгын газрын ахлах референт, Н.Удаанжаргал СЗХ-ны Тамгын газрын дарга, Р.Буд Уихын гишүүн, Н.Ганбямба УИХ гишүүн, СЗХ-ны гишүүн асан, Ц.Баярсайхан УИХ гишүүн, Д.Дүгэржав СЗХ-ны гишүүн бөгөөд дэд дарга, Зүүн гар талаас /Урд эгнээ/Б. Шаравсамбуу СЗХ-ны гишүүн бөгөөд дэд дарга, С.Дэмбэрэл УИХ-ын дарга, Д.Баярсайхан СЗХ-ны дарга



Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаан

ГОЛОМТ СЕКЮРИТИЗ

МОНГОЛД АНХ УДАА

Интернэт арилжааны систем



Интернэт арилжааны систем нь танд дараах

БОЛОМЖУУДЫГ ОЛГОНО

- Дэлхийн хаанаас ч, хүссэн үедээ арилжаанд оролцох
- Үнэт цаасны арилжааны мэдээллийг цаг тухай бүрийн мэдээлэлтэй авах
- Клиринг дансны өөрийн үнэт цаасны арилжааны явцыг хянах
- Өөрийн Хөрөнгө оруулалтын багцын хяналт
- Өөрийн Үнэт цаасны арилжааны явцын хяналт
- Нөхцөлт захиалгын төрөл
- Өгөөжийн тооцооллыг харах
- Захиалгын биелэлтийг харах
- Бэлэн мөнгөний үлдэгдэлийг хянах

www.golomtsecurities.com 976-70121530

ПРОГРЕССКАПИТАЛ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

5 Anniversary



Цаг хугацаа хэмнэсэн шуурхай зээл



Өндөр өгөөжтэй итгэлцлийн цйлчилгээ



Валют арилжаа



Танд зориулсан санхүүгийн зөвлөгөө

Таны итгэл
Бид бүгдийн алжилтын үндэс

Харилцагч Танд илүү ойртож
Сонгино Хайрхан дүүрэгт шинэ салбар нээлээ

21-252-252 9809-4080 9808-4080

www.progresscapital.mn